

kcg.edu

KCG: Kyoto Computer Gakuin **Академик программууд**

Японы анхны компьютерийн боловсрол олгох байгууллага **京都コンピュータ学院**

Киото компьютерийн Гакүин

kcg.edu

K y o t o C o m p u t e r G a k u i n

京都コンピュータ学院

URL: <https://www.kcg.ac.jp/>
E-mail: admissions@kcg.edu

Лавлах хаяг: Киото компьютерийн Гакүин
Элсэлтийн алба

10-5, Nishikujoteranomae-cho, Minami-ku,
Kyoto-shi, Kyoto 601-8407 Japan

TEL: 075-681-6334 (+81-75-681-6334)
FAX: 075-671-1382 (+81-75-671-1382)

Японд  0120-829-628

Киото компьютерийн Гакүин



1963 онд байгуулагдсан 1969 онд бүтэн өдрийн сургалтын хөтөлбөрийг бий болгосон

Японы анхны комьпютерийн боловсрол олгох байгууллага

Боловсролын үзэл санаа

- Компьютерийн технологийн судлалын чанарыг чухалчлан, онолыг орхигдуулдаггүй бодит боловсрол
- Компьютерийн технологийн дэвшил, хөгжилд нийцсэн боловсрол
- Компьютерийн технологи дахь зохион бүтээх ур чадварын бэлтгэл
- Мэдээллийн нийгэм дэх олон талын сэтгэн бодох чадварын сургалт
- Оюун, мэдрэхүй нь хослон шалгарсан хүн чанарын сургалт

Уламжлал ба амжилт



Үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч
Хасэгава Ясүко

Киотогийн их сургуулийн байгалийн шинжлэх ухааны салбарын сансрын физикийн танхимийг дүүргэсэн. (Эмэгтэйчүүдээс анхдагч)
Киотогийн их сургуулийн аспирантурт физик судлалын салбар дахь докторын хөтөлбөрийн төлөвлөгөөт кредитийг хангасан.
Сансрын физик судлал дахь компьютер хэрэглээний тэргүүлэх төлөөлөгч. АНУ-ын Пеннсилвани мужийн их сургуулийн зочин эрдэмтэн.
Тайланд, БНГанаУлс, Шри-Ланка, Перу тус тус улсуудын боловсролын ямаас шагнагдсан.
2006 онд Японы ITU нийгэмлэгээс Олон улсын харилцан туслалцааны тусгай шагнал хүртсэн.
2011 онд Мэдээлэл боловсруулалтын судалгааны нийгэмлэгээс талархлын бичиг хүртсэн.

1963 онд Японд анх удаа компьютерийн боловсрол олгох байгууллага болон байгуулагдсан. Түүнээс хойш Киото компьютерийн Гакүин (КСГ) нь ямагт цаг үеийнхээ тэргүүн эгнээнд алхсаар ирсэн.

КСГ-ын Pioneer Spirit

Киото компьютерийн Гакүин (КСГ) нь 1963 онд, Японы компьютерийн эрин үед шинэ эринийг бий болгох хүсэл эрмэлзлээс үүдэн байгуулагдсан. Японы компьютерийн боловсролын анхны тусгай байгууллага болох КСГ-ийг Киотогийн их сургуулийн Шинжлэх ухааны дээд сургуулийн Физик, одон орон судлалын сургуулийн (одоогийн тэнхим) бүлэг байгуулсан. Тэр үед Японы их дээд сургуулиудад мэдээлэл зүйн хичээлүүд байдаггүй байсан. Шинэ сургууль нь “эрин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээлч байдлаар мэдээлэл боловсруулах инженерүүдийг бэлтгэх” эрхэм зорилгыг өөртөө тавьсан.

1970-аад оноос 1980-аад оны эхэн үе хүртэл КСГ нь тухайн үеийн компьютерийн тэргүүлэгч тал байсан дунд болон том хэмжээний компьютеруудыг цувралаар нэвтрүүлж, оюутнууд сургалтын зориулалтаар чөлөөтэй ашиглах боломжтой болсон. Тухайн үед нэг сургууль оюутнуудыг сургалтын зориулалтаар тэрхүү хэмжээний хүчин чадал бүхий компьютерээр хангаж байсан нь бараг сонсогдож байгаагүй бөгөөд энэ бодлого нь бусад их дээд сургуулиудын атаархлын бай болж байв. Сургуулийн барилга нь хуаран төдий байсан ч КСГ нь тухайн үеийн хамгийн дэвшилтэт боловсролын орчинг оюутнуудад олгох боловсролын философидоо үнэнч гэдгээ харуулсан. Өнөөдөр КСГ нь үүсгэн байгуулсан анхдагч санаагаа үргэлжлүүлэн дэмжсээр байна. 2004 онд тус сургууль нь IT-ийн чиглэлээр мэргэшсэн Японы анхны ахисан түвшний сургууль болох Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургуулийг (КСГИ) нээсэн.

Өнөөдрийг хүртэл КСГ 50,000 орчим төгсөгчийг төрүүлжээ. КСГ-д төлөвшүүлсэн анхдагч сэтгэлгээтэй эдгээр төгсөгчид дэлхий даяар шинэ сорилтуудыг тасралтгүй даван туулж байна. КСГ нь өөрийн 60 гаруй жилийн өв уламжлал, гаргасан үр дүнтгээрээ бахархдаг. Одоо ирээдүйг бүтээх ажил таны гарт байна.



Киото Экимаэ Кампусын захирал
Тэрашита Ёиичи

Киотогийн их сургуулийн шинжлэх ухааны факультетийг төгссөн. АНУ-д Фулбрайтын тэтгэлэгт суралцсан. Айовагийн их сургуульд физикийн одон орон судлалаар шинжлэх ухааны магистр, философийн докторын зэрэг хамгаалсан. Айовагийн их сургуулийн багш. Пенсильвани мужийн их сургуульд судлаачаар дараалан ажилласан. Каназавагийн Технологийн дээд сургуулийн хүндэт профессор. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын (JICA) мэдээлэл зүйн түр мэргэжилтэн асан. КСГ-ийн Ракухоку Кампусын захирал асан. Одоогоор КСГ-ийн дэд захирлаар нэгэн зэрэг ажиллаж байгаа бөгөөд мэдээллийн сангийн чиглэлийн хичээлүүдийг хариуцдаг.

КСГ бол IT-ийн чиглэлээр ажилладаг цогц боловсролын байгууллага юм. Бидний санал болгож буй IT-ийн сургалтын хөтөлбөр нь IT-ийн онолоос эхлээд хэрэглээний IT, техник хангамжаас программ хангамж, технологи болох IT-ээс соёл болох IT хүртэлх нийгэмд хэрэгтэй бүхий л салбарыг хамардаг. Манай IT-ийн өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн факультет нь энэхүү сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хамгийн сүүлийн үеийн практик сургалтын хэрэглэгдэхүүнээр тоноглогдсон. Таны мөрөөдөл энэ сургуульд биелнэ гэж найдаж байна.



Камогава Кампусын захирал
Найто Шозо

Киотогийн их сургуулийн инженерийн бакалавр. Киотогийн их сургуульд математикийн инженер мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан. Инженерийн ухааны магистр. Ниппон Телеграф, Телефон Корпорацийн (NTT) Мэдээлэл тугээх платформын лабораторийн судалгааны ахлах ажилтан асан. Японы Электроник, мэдээлэл, харилцаа холбооны инженерүүдийн хүрээлэнгийн (IEICE) Интернет судалгааны хорооны нарийн бичгийн дарга асан. Солонгосын Мэдээллийн аюулгүй байдлын агентлагийн (KISA) зөвлөх, профессор асан. КСГ-н Профессор.

IT цаашид хөгжиж, IT-ийн мэргэжилтнүүдийн (инженерүүдийн) нийгмийн хэрэгцээ огцом өсөх болно гэдэгт эргэлзэх зүйл алга. IT-ийн салбарт шинэ технологиуд тасралтгүй хурдацтай гарч ирдэг тул мэдлэгээ шинэчилж байх нь чухал юм. Ийм учраас сурах чин хүсэлтэй хүмүүс эрэлт ихтэй байна. Та КСГ-д суралцаж, оюутны амьдралаар дамжуулан шинэ эрин үеийг удирдахад шаардлагатай хүч чадлаа олж авна гэж найдаж байна. Та бүхний хичээл зүтгэлийг багш нар бид дэмжих болно, тиймээс та бүхнийг өөрийн хэмжээндээ мэрийн суралцахыг уриалж байна.



Ракухоку Кампусын захирал
Ко Хонсөн

Өмнөд Солонгосын Донггук их сургуулийн инженерийн бакалавр. Докторын зэрэгтэй (тоон инженерийн чиглэлээр), Киотогийн их сургуулийн инженерийн ухааны доктор. Өмнөд Солонгосын Самсунг Электроникс ХХК-ийн Мэдээллийн стратегийн хэлтсийн Стратеги төлөвлөлтийн газрын гүйцэтгэх захирал асан. Harmony Navigation ХХК-ийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал асан. KISA-гийн зөвлөх, профессор асан. Ниппон Хэрэглээний Мэдээлэл зүйн Нийгэмлэгийн (NAIS) ерөнхийлөгч. Өмнөд Солонгос дахь CALS/EC нийгэмлэгийн Тусгай хорооны гишүүн. Чажугийн өөрөө удирдах тусгай мужийн зөвлөх асан. Чажугийн оюуны өмчийг дэмжих зөвлөх хорооны гишүүн. Солонгосын ЕС судалгааны нийгэмлэгийн анхны насан туршийн гишүүн. КСГ-н Профессор.

КСГ бол салбар бүрт нийгэмд хэрэгтэй IT судлах газар юм. Оюутнуудыг IT-ийн чиглэлээр суурь мэдлэгтэй болгохын тулд бид бүх хүчээ дайчилдаг. Гэхдээ үүнээс илүүтэйгээр бид өгөгдлийн шинжлэх ухаантай холбоотой технологи, бизнесийн төрөл бүрийн орчинд үнэ цэнэтэй үүрэг гүйцэтгэх чадвар бүхий хүмүүсийг бэлтгэхийг эрмэлздэг. Цаашид КСГ нь өгөгдлийн шинжлэх ухаан, хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн 4-р хувьсгал зэрэг хурдацтай өөрчлөгдөж буй салбарт компаниудын тогтвортой өсөлтөд зайлшгүй шаардлагатай хүмүүсийг бэлдэхэд идэвхтэй хувь нэмэр оруулахаар шийдсэн.

КСG-ийн үндсэн шинж чанарууд

Манай төгсөгчид бол хамгийн шилдгүүд юм! Таван тэнхимийн 20 хичээлээс та өөрийн хүссэнээр гүнзгий суралцах боломжтой.

Олон орны гадаад оюутнууд КСG-д суралцдаг!

► Японд байгуулагдсан анхны компьютерийн сургалтын институт.

► 60 гаруй жилийн түүхтэй, 50,000 гаруй төгсөгчтэй.

► Таван тэнхимийн 20 төрлийн хичээлтэй тул та IT-ийн бараг бүх чиглэлээр суралцах боломжтой.

► Японы эртний нийслэл, оюутны хот Киото хотод суралцах нь шилдэг сонголт юм.

► Сүүлийн үеийн тоног төхөөрөмж нь сургалтын гайхалтай орчинг бүрдүүлдэг.

► Иж бүрэн хүлээн авах байр нь дэлхийн өнцөг булан бүрээс олон тооны оюутнуудыг хүлээн авдаг.

► Дэлхий даяар 100 гаруй боловсролын байгууллагатай хамтран ажилладаг.

► Гадаад оюутнуудад зориулсан тусгай сургалтууд нь Япон хэл сурах боломжийг олгодог.

► Гадаад оюутнуудад сургалтын төлбөр болон бусад зардлаас чөлөөлөгдөх, хөнгөлөх өргөн хүрээний хөтөлбөрүүд байдаг.

► Тусгай туслах ажилтнууд нь гадаад оюутнуудын эрдэм шинжилгээний болон өдөр тутмын амьдралд тусалж дэмждэг.

► КСG нв оюутны дотуур байртай.

► Зөвхөн КСG-д хамаарах өргөн хүрээний тэтгэлэгт хөтөлбөрүүдтэй.

► Солилцооны оюутнууд солилцооны уулзалт, албан бус уулзалтын хуваарийн дагуу бие биетэйгээ танилцах боломжтой.

► Тохиромжтой сургалтын мөчлөг бүхий ажил хайхад зориулсан цогц дэмжлэгтэй.

► Гадаадын олон оюутан манай ах дүү КСG-д сургуульд IT болон менежментийн чиглэлээр суралцдаг.

► Сонирхсон оюутнууд манай ах дүү Киотогийн Япон хэлний сургалтын төвд элсэхээсээ өмнө япон хэл сурах боломжтой.



КСG дэх боловсрол

КСG-ийн боловсрол нь бусад сургуулиас олж авч чадахгүй өвөрмөц онцлогуудыг санал болгодог. Мэдлэгийг багшаас оюутанд шилжүүлэх уламжлалт хэв маягийг баримтлахын оронд КСG нь сурагч бүрийн хувийн онцлогийг хүндэтгэж, сургалтын арга барилыг олон удаа туршиж, өөрчлөх болон хамгийн сүүлийн үеийн боловсролын хэрэгслээр хангах замаар хувь хүний хүсэлтэд нарийвчлан нийцүүлдэг. КСG нь хичээнгүй, санаачлагатай оюутнуудыг мөрөөдлөө биелүүлэхэд нь хамгийн их дэмжлэг үзүүлдэг.

◆ Онцгой зан чанарыг хөгжүүлэх практик сургалтын хөтөлбөр

Бодит ертөнцтэй шууд холбогдож, салбар бүрийн удирдагчдын удирдан чиглүүлсэн хичээлүүд нь жинхэнэ чадварлаг хүмүүсийг бэлтгэдэг

■ Ирээдүйд идэвхтэй дүрд тоглож чадах хүмүүс

Нийгэмд идэвхтэй үүрэг гүйцэтгэхийн тулд зүгээр нэг цогц арга техник, мэдлэг олж авахаас хамаагүй илүү зүйлсийг шаарддаг. Энэ нь тухайн сурсан мэдсэнээ үр дүнтэй хэрэгжүүлэх, бодит ертөнцийн асуудалтай холбох жинхэнэ чадварыг шаарддаг. КСG-д бид ажлын байр дах сургалтын хөтөлбөр, практик сургалт-ыг санал болгодог бөгөөд энэ нь аж үйлдвэрийн ертөнцийн эрэлт хэрэгцээг тусгасан бөгөөд төгсөгчдөд ирээдүйн карьераа эхлүүлэх боломжийг олгодог.

Манай багш нар нь томоохон электрон бараа үйлдвэрлэгчид болон тоглоомын програм хангамжийн компаниудыг хамарсан байгууллагын практик туршлагатай тэргүүлэх мэргэжилтнүүд юм. Энэхүү бодит туршлага дээр үндэслэн эдгээр багш нар өнөөгийн бизнесийн ертөнцийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн практик боловсрол олгодог. Олон багш нар мөн IT-ийн мэргэжилтнүүдийг бэлтгэх Японы анхны мэргэжлийн ахисан түвшний сургууль болох КСG-ийн багш нарын гишүүд юм.

■ Өөрийн зорилго, мөрөөдлийнхөө дагуу суралцах

КСG-д бид баялаг сургалтын хөтөлбөр бүхий **сонгон суралцах систем**-ийг нэвтрүүлж, та өөрийн хэрэгцээнд тохирсон хичээлүүдийг сонгох боломжтой. Ингэснээр та өөрийн сонирхол болон туршлагад тохируулан суралцах боломжтой. Та өөр өөр факультет, тэнхимийн сургалтуудыг оролцуулан төгсөх шаардлагатай нэгжээсээ илүү олон хичээлийг судалж, оюуны эрэл хайгуулынхаа цар хүрээг өргөжүүлэх боломжтой.

Сургалтын хөтөлбөр нь таныг анхан шатны мэдлэгээс дэвшилтэт техник, мэдлэг рүү аажмаар чиглүүлдэг тул компьютерийн шинэхэн суралцагч ч гэсэн итгэлтэйгээр суралцах боломжтой.



◆ Төслийн судалгаанд хамрагдах замаар сайтар боловсруулсан чадварыг хөгжүүлэх

Семинарын хичээл нь таны техникийн ур чадвар болон ажил хайх ур чадварыг нэгэн зэрэг бий болгодог

Семинарын хичээл дээр оюутнууд хичээлийн жил бүр **төслийн судалгаа** явуулдаг. Ийнхүү хичээл тус бүрээр олж авсан ур чадвар, мэдлэг нь бие биенээ нөхөж, бататгаж, ашиглаж, хэрэглэхэд хялбар байх бүрэн цогц ур чадварыг хөгжүүлдэг. Оюутнууд аливаа асуудлыг зүгээр нэг судлахын оронд бүлгээрээ ажиллаж, зорилтоо тодорхойлж, төлөвлөж, загвар зохион бүтээж, боловсруулж, эцэст нь зорилгодоо хүрч, чанарын өндөр түвшинд төслөө гүйцэтгэдэг.

Техникийн чадвар нь өнөөгийн бизнесийн ертөнцөд амин чухал боловч энэ нь хангалтгүй юм. Орчин үеийн мэргэжилтнүүд **багаар ажиллах ур чадвар, манлайлах чадвар, хүн хоорондын харилцаа, цагийн менежмент, танилцуулга** гэх мэт чадваруудыг шаарддаг. Төслийн судалгаа нь бүлгийн ажлын явцад олон удаа

туршлага хуримтлуулснаар оюутнуудад эдгээр ур чадварыг зөнгөөрөө эзэмших боломжийг олгодог. Төсөлд заасан сэдвүүд нь нэг хичээлийн жилээс дараачийн хичээлийн жил хүртэл амарханаас хүнд рүү, энгийн ажлуудаас эхлээд нэлээд боловсронгуй, нарийн төвөгтэй ажлууд руу шилждэг тул та сургуулиа төгсөхдөө олж авсан практик чадварынхаа цар хүрээ, гүн гүнзгий байдлыг мэдрэх болно. Таны төгсөх жилийн төслийн судалгаа нь төгсөлтийн диссертацийг бүрдүүлэхэд түлхэц болдог судалгааны тань оргил үе юм.

Төслийн судалгааны үр дүнд бий болсон шилдэг бүтээлүүдийг жил бүрийн 2-р сард зохион байгуулдаг **КСG Awards Оюутны Төслийн Илтгэл**-ээр зарлаж, шагнаж урамшуулдаг.



◆ Оюутнуудын сурах хүсэл эрмэлзлийг хангах бүрэн хэмжээний цахим сургалт

Байршил, цаг хугацаагаар хязгаарлагдахгүйгээр өөрийн хэмнэлээр суралц

■ Хамгийн сүүлийн үеийн цахим сургалтын студи

Киото Екимаэ кампусын өргөтгөл нь хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон цахим сургалтын өргөн нэвтрүүлгийн студи, тэр дундаа шууд дамжуулалт хийх **алсын зайн лекцийн** систем, урьдчилан бичсэн контентыг лекцийн бичлэгийг хийх системээр тоноглогдсон. Энэхүү цахим сургалтын

студийг суурь болгон ашиглан KCG нь багш нарт хамгийн сүүлийн үеийн цахим сургалтын контентыг маш сайн нэвтрүүлгийн чанартайгаар бэлтгэж, түгээх боломжийг олгодог. Энэхүү систем нь оюутнуудад олон төрлийн суралцах боломжийг олгодог.



■ Хамгийн сүүлийн үеийн сургалтын менежментийн систем болох KING-LMS-ээр дамжуулан 24 цагийн тусламж дэмжлэг

Интернэтийн хандалт өргөн тархсан өнөө үед дэлхийн өнцөг булан бүрээс мэдээлэл авах нь маш хялбар болсон тул бид энэ чадварыг энгийн зүйл гэж үздэг. Энэхүү хөгжлийг урьдчилан таамаглаж байсан KCG нь онцгой **сургалтын удирдлагын системийг** (LMS) хэрэгжүүлсэн Япон дахь анхны боловсролын байгууллагуудын нэг юм.

Энэхүү системийг ашиглан оюутнууд хүссэн **контентоо** хаанаас ч, хэзээ ч компьютер эсвэл ухаалаг гар утсаараа **үнэ төлбөргүй, хялбар замаар судлах** боломжтой.



“KING-LMS”-г ашиглан суралцах

- Тус бүрийн сургалтын зориулалттай хуудсаас цахимжуулсан хичээл бүрийн үзэх материал руу орж, сургуулиас гадна гэрээсээ интернет ашиглан 24 цагын туршид чөлөөтэй суралцаж болно.
- Даалгавар, давтлага, даалгавар хураалгах, BBC (зарлалын самбар)-г ашигласан багш, оюутны, оюутан хоорондын мэдээлэл солилцоо, асуулт, хариулт хийх боломжтой.
- Өөрийн сонирхол болон тэмүүлэлдээ тохируулан бусад анги, бусад салбарын нээлттэй хичээл зэрэг өөрийн дүүргээгүй судлагдхуунаа бие даан суралцаж болно.
- Сургуулиас илгээсэн зарлал мэдээг шалгаж болно.

KING сүлжээ

KCG-д оюутнуудын ашигладаг бүх компьютерууд нь тусгай шилэн кабелиар дамжуулан интернетэд шууд холбогддог KCG Information Network Galaxy (KING)-ийн нэг хэсэг юм.

Оюутны онцгой вэбсайт

KCG-ийн оюутнуудад зориулсан онцгой вэбсайт болох KING-LMS нь хичээл сургууль, ажил хайх болон карьерын талаархи хамгийн сүүлийн үеийн мэдээллийг үргэлж өгдөг. Оюутнууд өдөр тутмын амьдралдаа хэрэгтэй мэдээллийг хаанаас ч, хэзээ ч шалгах боломжтой. Ухаалаг гар утсаараа нэвтрэх боломжтой.



◆ Ажил хайхад туслах цогц систем

Давхар зөвлөх систем болон IT-ийн тусламжтайгаар хамгийн тохиромжтой дэмжлэгийг олж авах

■ IT-ийн боловсон хүчний хомсдол нь цар тахлын үед ч хүчирхэг ажлын байрны зах зээлийг дэмждэг

COVID-19 цар тахал нь олон ажил хайгчдын хувьд хөдөлмөрийн зах зээлийг тодорхойгүй болгосон. Харин KCG-ийн оюутнууд болон төгсөгчдийн хувьд ажил хайх нөхцөл тогтвортой хэвээр байна. Учир нь Японд IT-ийн боловсон хүчин, тэр дундаа ахисан түвшний IT-ийн боловсон хүчний байнгын хомсдолоос гадна KCG-ийн оюутнууд нийгмийн өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хамгийн сүүлийн үеийн ур чадварт суралцах нь ашиг тустай байна. Цар тахлын улмаас үүссэн ноцтой өөрчлөлтүүдийн дунд хурдацтай өргөжиж буй салбарууд IT хэрэглээ, тухайлбал, зайнаас ажиллах, онлайн арга хэмжээ зохион байгуулах зэргээр хариу үйлдэл үзүүлж байна. KCG-ийн төгсөгчид бол өнөөгийн бизнесүүдэд яг хэрэгтэй хүмүүс юм.

■ Өргөн хүрээний үйлдвэрлэл болон салбар дахь идэвхтэй гүйцэтгэх үүрэг

Өнөө цагт IT-гүйгээр бизнесийг төсөөлөхийн аргагүй. Компьютерийн мэдлэг нь зөвхөн компьютерийн салбарт төдийгүй бизнесийн бараг бүх салбарт зайлшгүй шаардлагатай болсон. Үйлдвэрлэл, жижиглэнгийн худалдаа, санхүү, барилга, хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт олон салбарт ажилладаг компаниудад компьютертэй холбоотой мэдлэг, ур чадвартай боловсон хүчин байнга эрэлт хэрэгцээтэй байдаг. KCG-ийн төгсөгчдийн идэвхтэй үүрэг гүйцэтгэж чадах салбарууд үнэхээр хязгааргүй юм.

■ Хувь хүний нарийн зохион байгуулалтын удирдамж нь ажил хайх хамгийн тохиромжтой туршлагыг бий болгодог

Оюутнууд болон төгсөгчдийн сэтгэл ханамжтай ажил хайх туршлагад хүрэхийн тулд тэдэнд зөв зөвлөх хэрэгтэй. Энэхүү хэтийн төлөвийг харгалзан KCG-ийн ангийн багш нар болон Ажил мэргэжлийн төвийн зөвлөхүүд нягт уялдаатай ажиллаж, оюутан бүрийн онцлог шинж чанарыг үнэлж, ажил хайхад чухал зөвлөгөө өгөх шаардлагатай байдаг. Нэгдүгээр курсээс нь эхлэн давтан ярилцлагыг явуулж, оюутан бүрд ажил мэргэжлийн сонголт, суралцах зорилго болон бусад зүйлсийн талаар нарийн зааварчилгаа өгдөг. Ажил мэргэжлийн төвийн албан хаагчид ямар ч үед мэргэжлийн зөвлөгөө өгөх боломжтой. KCG-ийн ажил хайх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний ялгарах онцлог нь хүн бүрийн нарийвчилсан хэрэгцээг сайтар анхаарах явдал юм.



KCG группын өнгө

kcg.edu
Kyoto Computer Gakuin

KCG цэнхэр (Киото компьютерийн Гакүин (KCG) сургуулийн өнгө, KCG группын өнгө)

KCG сургуулийн өнгө болон KCG группын өнгө болох цэнхэр ньүүссэн байгуулагдах үеийн бүх гишүүд Киотогийн их сургуулийн аспирантурыг төгсөгчид байснаас үүдэн Киотогийн их сургуулийн өнгө болох хар хөхийг язгуур болгон сонгосон. 1970 оны орчмоос ашиглагдаж эхэлсэн боловч үүсэн байгуулагдсаны 35 жилийн ой (1998он) -ыг тохиолдуулан өнгөний зохицлыг тодорхойлж, KCG цэнхэр хэмээн тогтсон.

kcg.edu
The Kyoto College of Graduate Studies for Informatics

KCG улаан (Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль (KCGI) сургуулийн өнгө)

KCG группыг үүсгэн байгуулагч Хасэгава Шигэо нь амьдралынхаа сүүлийн жилүүдэд сургуулиа удирдахын хамт Харвардын их сургуульд суралцаж, залуу насандаа биелүүлж чадаагүй эрдэмд дахин шамдсан. Бостонд байр хөлслөн, залуу оюутнуудтай хамт утга зохиол, гүн ухааны хичээлүүдэд сууж байлаа. Зэрэг цол олгох Киотогийн мэдээллийн их сургуулийн өнгө болох хүрэн улаан өнгийг үндэс болгон KCG цэнхэртэй жишсэн өнгийн хоршил болгон баталсан. Энэ нь хөгшин залуу, эр эмээс үл хамааран ямагт шинэ зүйлд өөрийгөө сорьж, даруу төвшинөөр суралцах төлөв байдлыг илэрхийлж байгаа юм.

kcg.edu
Kyoto Japanese Language Training Center

KCG ногоон (Киото япон хэл сургалтын төв (KJLTC) сургуулийн өнгө)

KCG группын гадаадаас ирсэн оюутнуудын хувьд эхний үүд хаалга болдог Киото япон хэлний сургалтын төв нь, хууль зүйн сайдын заасан япон хэлний сургууль бөгөөд “БСШУЯ”-аас бэлтгэл боловсролын судлагдахууны зааврыг авсан. Дэлхийн 7 тивийн ногоон их газрын дүрслэлээс сургуулийн өнгө болгон дээрхи KCG цэнхэр болон KCG улаантай хорших өнгө хослолыг ногооноор тогтсон.

kcg.edu
Kyoto Computer Gakuin Automobile School

KCG улбар шар (Киото автомашины мэргэжлийн сургууль (KCGM) сургуулийн өнгө)

Киото автомашины мэргэжлийн сургуулийн өнгө нь 2013 онд тус сургууль KCG группд орох үед шийдэгдсэн. Улбар шар өнгө нь эрч хүчтэй, эерэг дүр төрхийг илэрхийлдэг ч аюулгүй байдлыг хангах үүднээс үзэгдэх байдлыг сайжруулахад ашигладаг. Энэ нь өнөөгийн автомашин жолооддог нийгэм дэх аюулгүй байдлын эрэл хайгуул, оюутнуудын бэрхшээлийг даван туулахын тулд эрч хүчтэй хүчин чармайлтыг бэлэгддэг.

Хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж

Тоног төхөөрөмж болон орчин нь бусад сургуулиудаас ялгаатай
Хамгийн сүүлийн үеийн 700 компьютер

КСГ-д бид нэн тэргүүний зорилгоо биелүүлэхийн тулд бүх хүчин чармайлтаа дайчлан ажилладаг. КСГ нь оюутнуудад хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан чөлөөтэй суралцах, судлагаа хийх орчныг нь бүрдүүлж өгдөг. Боловсролын чанар бол бидний хувьд маш чухал зүйл юм. Манай сургууль маш хурдацтай өсч хөгжиж, туршлага хуримтлуулж байгаа бөгөөд үүнийхээ хэрээр бид боловсролын философи дахь амлалтандаа урьд урьдынхтайгаа адил тууштай байх болно.

Илүү их
судла



Тоглоом хөгжүүлэлтийн практик сургалтын өрөө



Програмчлалын практик сургалтын өрөө



Сүлжээний практик сургалтын өрөө




Мас аппликейшн хөгжлүүлэлтийн лаборатори



Мэдээллийн сангийн практик сургалтын өрөө



Мас дизайны лаборатори




Мехатроникийн практик сургалтын өрөө



Компьютерийн тусламжтайгаар загварчлах (CAD) /
Инженерийн програмчлалын практик сургалтын өрөө



Тусгай эффект ба аниме лаборатори



Цахилгаан ба цахилгаан хэлхээний үйлдвэрлэлийн дадлагын өрөө



3D компьютерийн график үйлдвэрлэлийн практик сургалтын өрөө



Автомашины хяналтын практик судалгааны талбай



Уян хатан ангиуд



Их танхим



Цахим сургалтын студи



Мэдээллийн станц



Дуу бичлэгийн студи



Оюутны амралтын өрөө

KCG AWARDS

Оюутны төслийн илтгэл

Илүү их
судла



◆ Манай төгсөгчид үнэхээр шилдэг нь юм. KCG Awards үүнийг баталж байна.

Жил бүр KCG нь KCG Awards Оюутны Төслийн Илтгэлүүдийг толилуулдаг. Жил бүр зохиогддог энэхүү арга хэмжээнд оюутнууд тухайн жилийн хэрэгжүүлсэн төслийнхөө үр дүнг, тэр дундаа *шилдэг бүтээл*, төгсөлтийн жилийн төслүүдээ зарладаг. Эдгээр оюутны төслүүдээс хамгийн шилдэг бүтээлийг шалгаруулж, олон нийтэд танилцуулахдаа шилдэг бүтээлийн шагналаар шагнадаг. Олон төслүүдийг тун удахгүй арилжаанд оруулахад бэлэн болж, бизнесийн болон эрдэм шинжилгээний салбараас талархал хүлээж байна.

◆ Олон улсын оюутнууд ч энэхүү уралдаанд идэвхтэй оролцож, шилдэг төслийн шагнал, шилдэг шагналыг хүртдэг.

Жил бүр олон улсын оюутнууд KCG Awards оюутны төслийн танилцуулгад идэвхтэй оролцдог. 2019 онд БНХАУ-ын Лю Лангбяо болон Япон оюутан нар Тоглоомын хөгжлийн танилцуулга ангид элсэн орж, Haptic Game: Шидэт хавтаснуудыг бүтээж, шилдэг төслийн шагналыг хүртсэн. 2021 онд Мэдээллийн инженерийн чиглэлээр элсэн орсон Вьетнам оюутан Нгуен Тан Манх ангийн найз болох Япон оюутны хамт робот тоос сорогч бүтээж шилдэг шагнал хүртсэн.



Haptic Game: Шидэт хавтаснууд

Тоглоомын хөгжлийн танилцуулга **Лю Лангбяо, Үэда Цүбаса**

Энэ тоглоом нь Twister шиг ажилладаг бөгөөд аркад хянагч ашиглан тоглогчид бие биетэйгээ оюун санааны болон бие бялдрын хувьд эсэргүүцэх “шидэт шившлэг” системтэй холбогдож ажилладаг.



Энэхүү шинэ үзэл баримтлалтай, шидэт шившлэгийг нэгтгэдэг, нэг тоглогч нөгөө тоглогчоо бууддаг тоглоомонд тоглогчид бодит цаг хугацаанд бие биедээ шившлэг нэгтгэхийн тулд өвөрмөц тоглоомыг ашигладаг. Тоглоом эхэндээ саад тотгор бага боловч бүрэн хэмжээний байлдааны ажиллагаа удахгүй нарийн төвөгтэй болдог.



Робот тоос сорогч

Мэдээллийн инженерчлэл
Нгуен Тан Ман, Араки Каору

Энэхүү робот тоос сорогч нь өрөөнүүдийг автоматаар цэвэрлэдэг. Дээд талын хянах самбар нь цэвэрлэгээг эхлүүлэх, зогсооход ашиглагддаг. Роботыг Wi-Fi функцийг ашиглан алсаас ухаалаг утсаар удирдах боломжтой.



Унадаг дугуйны аюулгүй байдлын компьютер

Дижитал тоглоом, зугаа цэнгэл
Ивахори, Такахаши, Икома, Танабэ

Энэхүү төхөөрөмж нь унадаг дугуйнд бэхлэгддэг. Бариулын хэсэг нь CSC микроконтроллер, дэлгэц агуулдаг бол дугуйны их бие нь хэт авианы мэдрэгчээр тоноглогдсон байдаг. Дэлгэц нь хурд, цаг агаарын мэдээ гэх зэргийг харуулахаас гадна LED гэрэл болон хойноос ойртож буй тээврийн хэрэгслийн дуу чимээг ашиглан жолоочид дохио өгдөг.



Юша Мини

Дижитал тоглоом, зугаа цэнгэл **Яаманака, Мураяама, Ичикава**
Суулгагдсан системийн инженерчлэл **Тан**


Зөн совингоор ажиллах энэхүү тулаан нь тоглоомыг хөгжилтэй болгодог. Дайсан руу тасралтгүй довтолсноор тоглогчид довтолгооны хослолуудыг бүрдүүлж, баатар болох Юшаг хүчирхэгжүүлдэг. Тоглогчид мөн ялагдсан дайснуудын араас хөөн мөшгиж, хүчирхэгжүүлэгч олж авах боломжтой. Юша довтолгооны асар их нөөц болон хүчирхэгжүүлэгч олж аван хүчирхэг болсноор ямар ч дайсныг нүд ирмэхийн зуур унагааж, үгээр илэрхийлэхийн аргагүй хүчийг бий болгож чадна.



Бичил хулгана (Цэнхэр гэрэл) хөгжүүлэлт

Суулгагдсан системийн инженерчлэл **Хаяаши**

Бид Бичил хулгана нэртэй өрсөлдөх чадвартай робот зохион бүтээсэн. Роботод гол бай бүхий байршлыг зааж өгөхөд тэрээр бай руугаа бие даан хөдлөх явцдаа төврдөг байшинг гатлах болно. Бид өмнө нь сурсан мэдлэг, арга барилаа давтах замаар Бичил хулганыг гэрийн даалгавар дээрээ хийсэн.



Blackbird (Хар шувуу)

Компьютерийн шинжлэх ухаан
Исобо, Яамада, Сугияама, Дой, Обара

Энэхүү аппликейш нь хамгийн тохиромжтой олон нийтийн хэрэгслийг бий болгохын тулд бүтээгдсэн. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мөн чанарыг харгалзан Хар шувуу нь өндөр түвшний аюулгүй байдлын үүднээс хамгаалалтын хатуу арга хэмжээнүүдийг авч бүтээгдсэн. Серверийн талыг нь Python орчинд зориулсан Django REST Framework ашиглан хөгжүүлсэн. Хэрэглэгчийн талын програмыг JavaScript болон React ашиглан боловсруулсан.



Dirty Planet (Бохир гариг)

Дижитал тоглоом, зугаа цэнгэл
Усуй, Мацуда, Хаттори, Мори, Фужита

Дөрөв хүртэлх хүн тоглох боломжтой 3D буудлагын адал явдалт тоглоом. Бохир гариг нь довтолгоо, хамгаалалт, зөрчилдөөн дээр суурилж, чөлөөтэй төсөөллийн хүчээр тоглодог. Тоглогчид оддын хоорондох өвчнийг үүсгэдэг бохирдлыг устгах замаар эмчилдэг эмч нар юм. Гол зорилго нь эцсийн шатанд хамгийн дотоод цөмд хүрч, түүнийг цэвэршүүлж дуусгах юм.



Boozer (Архины мухлаг)

Компьютерийн шинжлэх ухаан **Кикузаки, Ивасаки, Огава, Окамото**

Энэхүү вэб програм нь шинээр гарч ирж буй коктейль найруулагч нарт хялбар коктейль бүтээхэд нь туслах зорилготой. Хэрэглэгчид урвуу хайлт ашиглан орц найрлага, өнгө, согтууруулах ундааны агууламж, амт зэрэг олон үзүүлэлтийг тодорхойлж, өөрсдөө тохирсон коктейлийг хялбархан гарган авах боломжтой. Энэхүү аппликейш нь нэмэгдсэн бодит зүйлсийг ашиглан дурын шилний гадна талд нарийн хэмжүүртэй тэмдэглэгээ зурдаг тул хэрэглэгчид орцыг хэмжихгүйгээр коктейль бэлтгэх боломжтой.



Тоглоом ба Анимэ

КСГ нь олон төрлийн тоглоом, анимэ арга хэмжээнд оролцдог!

Японы видео тоглоом, анимэ нь өндөр түвшний техникээр хийгддэг бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт байгаа шүтэн бишрэгчдийн хайр, хүндэтгэлийг хүлээдэг. КСГ-д бид тоглоом, анимэ бүтээх сургалтуудыг санал болгодог. КСГ нь олон төрлийн холбогдох арга хэмжээнд идэвхтэй оролцож, оюутнуудын ур чадвар, амжилтын түвшинг дээшлүүлдэг. Энд жагсаасан арга хэмжээнүүд нь зөвхөн КСГ-ийн оролцдог олон үзэсгэлэн, тэмцээнүүдийн жишээ юм.

Жил бүр болдог Unreal Fest West



Жил бүр КСГ нь Unreal Engine (UE) хөгжүүлэгчид болох Epic Games, Inc.-ийн Япон дахь салбар компаниас ивээн тэтгэдэг албан ёсны, томоохон хэмжээний судалгааны уулзалт болох Unreal Fest West-г зохион байгуулдаг. КСГ-ийн багш нар болон олон оюутнууд үйл ажиллагааг амжилттай болгохын тулд хамтран ажилладаг. КСГ дээр бид UE ашиглан тоглоом бүтээх хичээлүүдийг санал болгодог тул Unreal Fest West-д оролцох нь оюутнуудад ур чадвар, мэдлэгээ дээшлүүлэх боломжийг олгодог. Мөн бид UE-ийн практик семинаруудыг танилцуулах чиглэлээр хамтран ажилладаг.

Unity Dojo Kyoto Special-дэх өндөр түвшний оролцоо



Unity тоглоомын хөдөлгүүрийг Fate/Grand Order, Pokémon GO, Super Mario Run зэрэг алдартай тоглоомуудыг хөгжүүлэхэд ашигладаг. КСГ нь олон зуун оюутнууд оролцсон КСГ Киото Экимае кампус дээр Эв нэгдэлтэй холбоотой Unity Dojo Kyoto Special хэмээх томоохон хэмжээний сургалтын хуралдаан зохион байгуулсан. Ивээн тэтгэгч нь Cloud Creative Studios, Inc. нь олон тооны КСГ төгсөгчдийг ажилд авдаг тоглоом хөгжүүлэгч юм; Энэ жилийн арга хэмжээнд оролцож буй олон оролцогчид болон VR тоглоомын туршлагын асрын хөтөлгөч нар КСГ-ийн төгсөгчид байсан.

Киотогийн поп соёлыг дэлхийд түгээн дэлгэрүүлэх KYOMAF-г ивээн тэтгэж байна



КСГ групп нь жил бүрийн намар Киото хотноо зохиогддог олон улсын манга анимэ үзэсгэлэнг (KYOMAF) ивээн тэтгэж байгаадаа баяртай байна. Энэхүү арга хэмжээг зохион байгуулахдаа КСГ Киото хотоос поп соёлыг дэлхий дахинд хүргэхийн төлөө хүчин чармайлтаа гаргаж байна. Жил бүр олон мянган манга, анимэ шүтэн бишрэгчид Японы өнцөг булан бүрээс KYOMAF-д цуглардаг бөгөөд зарим нь КСГ-ийн асарт урт дараалал үүсгэдэг. COVID-19 цар тахлын үеэр мэргэжлийн аниматорууд дижитал урлагийн үзүүлбэрүүдийг онлайнаар дамжуулж, анимэ бүтээх үйл явцыг тайлбарласан шууд лекцүүдийг толилуулжээ.



Киокотан бол КСГ-ийн албан ёсны сахиус юм. Энэхүү сахиусыг КСГ-ийн оюутнууд, багш нар, мэргэжлийн уран бүтээлчид өргөн хүрээний загвар, хэлбэрээр бүтээсэн. Та Киокотанг KYOMAF зэрэг олон төрлийн арга хэмжээнүүдээс үзэх боломжтой.

КСГ-н архивын сан



Мэдээлэл боловсруулалтын нийгэмлэгийн итгэмжлэлтэй

Хаа сайгүй тархсан компьютерийн музейн улсдаа хамгийн анхных нь

КСГ нь японд хамгийн анхны “Компьютерын музей”-г бий болгохоор бэлтгэл ажлаа эхлээд байна. Киото буудлын өмнөх сургуульд “Мэдээлэл боловсруулалт, технологийн өв”-н сертификаттай тоног төхөөрөмжийн үзүүлэн гаргаж, сургалтын орчинтой нэгтгэж байна.

Япон улсын анхны компьютерын боловсрол олгох байгууллага болох Киотогийн компьютерын сургууль “КСГ” нь байгуулагдсан цагаасаа хойш 60 гаруй жилийн хугацаан дах сургалт, дадлага туршлага, судалгаанд ашиглаж байсан компьютер, техник хэрэгслийг хадгалж байдаг бөгөөд тэдгээрийг ашиглан “Компьютерын музей” байгуулахаар бэлтгэл ажлуудыг хангаад явж байна. КСГ-ийн “КСГ-ын материалын архив”-т нэлээдгүй улсын хэмжээнд ашиглагдаж байсан чухал тоног төхөөрөмж хадгалагдаж байдаг бөгөөд 2009 онд Япон улсын Мэдээллийн боловсруулалтын нийгэмлэгээс “Төрөлжсөн компьютерын музей” ангиллын Япон улсдаа анхны зөвшөөрлийг олгосон юм. Мөн “TOSBAC-3400”болон “OKITAC-4300C систем”-үүд нь анхны “мэдээллийн боловсруулалтын технологийн үнэт өв”-өөр өргөжлөгдсөн байдаг. 2011 онд “NEAC-2206” нь мөн адил “мэдээллийн боловсруулалтын технологийн үнэт өв” болж, сургуулийн захирал хатагтай Хасэгава Ясүко-д дээрх нийгэмлэйн зүгээс баярын бичгээр шагнагдсан юм. Улмаар 2012 онд дахин шинээр “NEAC систем100” болон 2013 онд “MZ-80K” зэрэг нь “мэдээллийн боловсруулалтын технологийн үнэт өв”-өөр тус тус бүртгүүлээд байна.

Киотогийн буудлын сургуулийн байранд эдгээр “мэдээллийн боловсруулалтын технологийн үнэт өв”-үүд болон бусад түүхэн чухал тоног төхөөрөмжийн үзэсгэлэн оршдог. Япон улсын ид хөгжлийн үед чухал үүрэг гүйцэтгэж ирсэн тэдгээр төнөг төхөөрөмжийг сонирхох гэж маш олон хүмүүс үзэхээр зорьж очдог юм.

Компьютерын технологийн хурдацтай хөгжлийг дагаад мэдээлэл боловсруулах тоног төхөөрөмж мөн адил хурдацтай хөгжиж байна. КСГ-д арван хэдэн жилийн өмнөөс үе үед шинэчлэгдэн өөрчлөгдөж ирсэн техник технологи, бүтээгдэхүүнийг хадгалж авч үлдэх хэрэгтэй гэж үзэн, “Компьютерын музей”-г байгуулахаар шийдэн ажиллаж байна. Манай улс нь технологийн өндөр хөгжсөн улс бөгөөд цаашид ч дэлхийн хэмжээнд тэргүүлэх зэргийн технологийн дэвшлийг бий болгох хүлээлттэй байгаа энэ үед тухайн техник технологийн өнгөрсөн үе, түүхэн замналыг харуулсан музей байгуулах нь асар чухал ач холбогдолтой юм.

КСГ нь Киотогийн буудлын сургуулийнхаа байрыг манай улсын бахархал болсон “Компьютерын музей” болгохоор зорин ажиллаж байгаа бөгөөд холбогдох хуулийн этгээдийг байгуулах, мөн Засгийн газар болон Киото хотын удирдлага, боловсролын салбар, компаниуд зэрэг холбогдох этгээдүүдтэй хамтран ажиллахаар хичээж байна.



Физик-химийн судалгааны хүрээлэн (Рикен), Фүжицу Лимитед K computer



Мэдээлэл боловсруулалт, технологийн өв TOSBAC-3400 (2009 оны 3 сарын 2 өдрийн сертификаттай)



Мэдээлэл боловсруулалт, технологийн өв OKITAC-4300C систем (2009 оны 3 сарын 2 өдрийн сертификаттай)



Мэдээлэл боловсруулалт, технологийн өв NEAC-2206 (2011 оны 3 сарын 2 өдрийн сертификаттай)



Мэдээлэл боловсруулах технологи нь өв NEAC систем 100 (2012 оны 3 сарын 6 өдрийн сертификаттай)



Мэдээлэл боловсруулалт, технологийн өв MZ-80K (2013 оны 3 сарын 6 өдрийн сертификаттай)



Мэдээлэл боловсруулалт, технологийн өв PDP 8/I (2015 оны 3 сарын 17 өдрийн сертификаттай)



Мэдээлэл боловсруулалт, технологийн өв TOSBAC-1100D (2016 оны 3 сарын 10 өдрийн сертификаттай)

Бизнесийн тэргүүн эгнээний
мэргэжилтнүүдийн тавьсан лекцүүд

“Хацүнэ Мик”-н Crypton Future Media ХК-н захирал

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг
олгох их сургууль (KCGI), Профессор

Итох Хироюки

“Ирээдүйгээс ирсэн эхний чимээ”-гээс улбаатай зохиомол шүтээн нь дууны үг болон аяыг компьютерт суулгангуут хоршмол хоолойгоор дуулж өгдөг. Дотоод төдийгүй далайн чандад ч амьд тоглолт зохиогдож, олон шүтэн бишрэгчийн сэтгэлийг хөдөлгөдөг. Энэхүү их амжилтыг түрсэн дууг хоршуулах программ хангамж “Хацүнэ Мик”-г зохион бүтээгч Crypton Future Media Inc. компанийн гүйцэтгэх захирал Итох Хироюки нь KCG-ын багшаар томилогдсон.



Компьютер болон авианы нийлүүлэлтийн программ хангамжийг зохион бүтээсээр байгаа Ито багш бол ирээдүйн мэдээллийн технологийн ертөнцийг нуруундаа үүрэлцэхээр зүтгэж буй залууст хандан “дөнгөж замын талдаа гэж хэлж болох “Мэдээллийн Хувьсгал”-н хилийн хязгаар нутаг бол нүд алдам их бөгөөд оюутнуудын өмнө хязгааргүй дэлгээстэй байна. Түүнийг бүрэн мэдэрч, эрдэмдээ шамдаасай” гэж захиж байна. Ито гуайн яриаг сонслоо. Бид профессор Итотой ярилцлаа.

KCGI-ийн профессор Хироюки Ито Vocaloid программ хангамжийн дуу хоолойны банк болох
Хицүнэ Мик-ийн хөгжүүлэлтийг дурсахдаа сэтгэл дүүрэн ярьж байна. (KCG-н Их танхим, Экимаэ кампус)



Манай компани тоглоом болон анимэ зурагт ном хийдэг компани биш. Хөгжимтэй холбоотой ажил хийдэг ч дуу бичлэгийн компанитай адилхан биш. Сонирхон оролддог компьютерийн хөгжмийг бизнестэй холбосон нэг бодлын “Дуу оруулагч” гэж болно. “Хацүнэ мик”-г 2007 оны 8 сард борлуулж эхэлсэн бөгөөд энэ нь хүмүүст ажил үйлстээ бүтээлчээр шамдан ажиллах боломжийг олгож өгсөн гэж бодож байна.

Хүн төрөлхтөн өнгөрсөн үедээ гурван том хувьсгалыг даван туулж ирсэн гэж ярьдаг. Эхний хувьсгал нь хөдөө аж ахуйн хувьсгал. Ан агнуур хөөж яахын аргагүй нүүдэллэхээс өөр аргагүй болж ирсэн хүн төрөлхтөн энэхүү хувьсгалаар хүнс тэжээлээ төлөвлөгөөтэйгөөр үйлдвэрлэж, үржүүлж чаддаг болж ирсэн тул, тогтсон газар нутагт суурьшиж эхэлсэн. Үүнээс нийгэм, улс төр үүсэн бүрэлдэж, нөгөө талаар баян ядуугийн ялгаа гарч эхэлсэн. Эдийн засгийн өсөлттэй зэрэгцэн дайн тулаан гарах болсон шалтгааныг үүсгэсэн ч гэж хэлж болно.

Хоёр дахь хувьсгал нь аж үйлдвэрийн хувьсгал юм. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, адилхан зүйлийг үр өгөөжтэй хийж бүтээх арга зүй хөгжсөнөөр, их хэмжээгээр үйлдвэрлэж, их хэмжээгээр хэрэгцээгээ хангаж эхэлсэн. Гадаад худалдаанд ахиц гарч, бүс нутгийн хэмжээгээр элбэг баян болоход нөлөөлсөн. Мөн, энэ хувьсгал нь “хүн амын огцом өсөлт”-г бий болгосон. Аж үйлдвэрийн хувьсгалын өмнө, олноор үйлдвэрлэж, олноор үхэж үрэгдэж байсан үе байсан ба хүн амын өсөлт тогтворжиж, нийгмийн давхаргын ялгаа багасч ирсэн боловч аж үйлдвэрийн хувьсгалаар, хүн амын өсөлт асар хурдтайгаар нэмэгдсэн.

Түүнчлэн, гурав дахь хувьсгал нь интернэтээр тэргүүлсэн мэдээллийн технологийн мэдээллийн хувьсгал байлаа. Интернэтээс өмнө, мэдээллийг түгээгч нь хязгаарлагдмал, өвөрмөц байдалтай байсан. Түгээгч нь сонин хэвлэл болон телевиз, радиогийн студи, хэвлэлийн компани гэх мэт мэдээллийн агентлагууд байсан ба эдгээр нь мэдээллийг түгээхдээ тоног төхөөрөмж болон хүн хүчдээ асар их хэмжээний зардал гаргадаг байв. Түүнчлэн энэ үеийн мэдээллийн багтаамж бага, зөвхөн нэг урсгалын байсан. Гэвч, интернэт үүссэнээр энэхүү хувьсгал гарах болсон. Мэдээллийг түгээх арга барилд ихээхэн өөрчлөлт орсон.

Одоо, интернэтийн хэрэглээ нь ердийн үзэгдэл болж, гар бүртээ, ширээн дээрээ, халаасандаа ч авч яваад ашиглах боломжтой болжээ. Мэдээ, кино, дуу хөгжим зэрэг дижиталчлагдсан мэдээллийг интернэтээр дамжуулан хялбархан түгээж, хуримтлуулж байна. Өөрийнхөө дуртай дүрс бичлэг, нэвтрүүлгийг дуртай үедээ үзэж харж, амьдрал болон ажлаа хялбарчлан хөгжилтэй өнгөрөөх боломжтой болоод байна. Мөн, энэхүү мэдээллийг өөрийнхөө мэдээтэй холбон, Facebook ба X, блогоор дамжуулан өөрийнхөө тухай хялбархан, хурдан, дэлхий дахинд цацаж болдог болоод байна.

Гэвч, энэхүү мэдээллийн хувьсгалын өөрчлөлт дөнгөж эхлээд байна гэж бодож байна. Хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэлийн хувьсгал нь хүн төрөлхтөний ахуй амьдралд ихээхэн өөрчлөлтийг авч ирсэн. Мэдээллийн хувьсгалыг авчрах өөрчлөлт нь одоогоор тийм өндөр түвшинд хүрээгүй байна. Нэг их удахгүй, цаашид жинхэнээр өөрчлөгдөж эхлэх боловуу. 20-30 жилийн дараа, хүний амьдрал, дэлхий дахиныг зүйрлэхийн аргагүй өөрчлөх байх. Гэвч, хэрхэн яаж өөрчлөгдөхийг мэдэхгүй юм. Яаж өөрчлөх вэ гэдгийг бид бүхэн болон бидний ирээдүйн залгамжлагчдын гарт атгагдаж байна.



Art by KEI © Crypton Future Media, INC. www.piapro.net piapro



Таван тэнхимийн 20 курстэй тул таны хүсэл тэмүүлэл таныг хааш нь хөтөлж чадах вэ гэдэгт хязгаар байхгүй

Дөрвөн жилийн хөтөлбөрийн төгсөгчид Нарийн мэргэжилтний дипломтой болно

Тодорхой болзол хангасан, мэргэжлийн ахисан түвшний сургуульд дөрвөн жилийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан оюутнуудад Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайдын (БСШУСЯ-ны сайд) “Нарийн мэргэжилтний диплом” (*кодо сенмонши*) олгоно. Нарийн мэргэжилтний диплом эзэмшигчид олон тохиолдолд их дээд сургууль төгссөн бакалаврын зэрэгтэй дүйцэхүйц буюу түүнээс дээш мэргэшсэн чиглэлээр мэдлэг, ур чадвар эзэмшсэн гэдгээрээ нийгэмд хүлээн зөвшөөрөгддөг. KCG-д A, B, C, D, E тэнхимүүдэд Нарийн мэргэжилтний диплом авах боломжтой дөрвөн жилийн хөтөлбөрийг санал болгодог. Дөрвөн жилийн курсээ дүүргэснээр та ахисан түвшний сургуульд элсэн суралцах боломжтой болно. KCG-ийн олон төгсөгчид KCG группын хамтран ажилладаг байгууллага болох KCGI-д элсэн суралцдаг.

Таван тэнхимийн дөрвөн жилийн хөтөлбөрүүд нь Мэргэжилтний мэргэшил дээшлүүлэх практик сургалтын хөтөлбөр баталгаажсан

MEXT нь “Мэргэжлийн сургуулиудын мэргэжлийн боловсролын сургалтын түвшинг дэмжих, сайжруулах” зорилгоор “Мэргэжилтний мэргэшил дээшлүүлэх практик сургалтын анги”-ийг нэвтрүүлсэн. Мэргэжилтний мэргэшил дээшлүүлэх практик сургалтын анги нь аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажилладаг сургалт, боловсролын хөтөлбөрүүдээс бүрддэг. Сертификат авахын тулд оюутнууд түншийн ажлын байранд сурч, ур чадвар эзэмших ёстой. KCG-д таван тэнхимийн дөрвөн жилийн хөтөлбөрүүд нь “Мэргэжилтний мэргэшил дээшлүүлэх практик сургалтын анги” гэсэн гэрчилгээтэй. Эдгээр хөтөлбөрүүд нь аж үйлдвэрийн тэргүүн эгнээнд ажиллаж байгаа компаниуд болон одоогийн идэвхтэй мэргэжилтнүүдтэй хамтран практик, тусгай боловсролыг санал болгодог. KCG нь бусад хэлтсүүдэд дараалан гэрчилгээ авах бэлтгэл ажлыг хийхээр төлөвлөж байна.

A

Арт, дизайн (Art & Design)

Тэргүүлэх дижитал уран бүтээлчдидтэй нэгдээрэй

Арт, дизайны мэдээлэл зүйн хөтөлбөр

Арт, дизайны мэдээлэл зүйн анги / Манга, анимэгийн анги

4 жил

Арт, дизайны ахисан түвшний хөтөлбөр

3 жил

Манга, анимэгийн хөтөлбөр

3 жил

Арт, дизайны хөтөлбөр

Дотогшоо бизнесийн захирлын гэрчилгээ олгох шалгалт нь тухайн эзэмшигч Японд ирэх гадаадын жуулчдад чиглэсэн дотогшоо аялал жуулчлалын бизнесийг хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэгтэй болохыг баталгаажуулдаг ур чадварын шалгалт юм. Энэхүү шалгалтад тэнцэхийн тулд дотогшоо аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлагын талаарх мэдлэг, үйлчлүүлэгчдийг татахуйц бизнес төслүүдийг төлөвлөх чадвар, Японд ирж буй гадаадын жуулчдын талаарх ойлголт, хариу арга хэмжээ авах чадвар, “шинэ аялал жуулчлал” болон үзвэр үйлчилгээний газруудын талаар мэдлэгтэй байх шаардлагатай.





КСГ гадаад оюутнууд: Өргөдөл гаргахад тавигдах шаардлага

Мэргэшсэн өргөдөл гаргагч нь дараах шалгуурыг хангасан гадаадын иргэд юм.

(1) Өргөдөл гаргагч нь Японд болон/эсвэл өргөдөл гаргагчийн эх оронд 12 жилийн сургуулийг төгсөх гэж байгаа эсвэл төгссөн байх; эсвэл өргөдөл гаргагч эх орондоо их сургуульд элсэн суралцах шаардлага хангасан байх; эсхүл дээрхтэй дүйцэхүйц мэргэжилтэй байх.

Өргөдөл гаргагч нь КСГ-тай сайн харилцаатай байх, 18 ба түүнээс дээш настай, дараах таван нөхцлийн нэг буюу хэд хэдэн шаардлагыг хангасан, лекцийг ойлгох Япон хэлний мэдлэгтэй байх.

1) Өргөдөл гаргагч нь Японы сан болон Японы боловсролын солилцоо, үйлчилгээний газраас явуулдаг Япон хэлний түвшин тогтоох шалгалтын (JLPT) N1 (1-р түвшин) эсвэл N2 (2-р түвшин)-д тэнцсэн байх.

2) Өргөдөл гаргагч нь Японы Оюутны Үйлчилгээний Байгууллага (JASSO)-аас явуулдаг Японы их сургуульд элсэх шалгалтад (EJU) нийт 200-аас доошгүй оноо (унших, сонсох, сонсох / уншиж ойлгох хосолсон) авсан байх.

3) Өргөдөл гаргагч нь Японы Ханзийн ур чадварын шалгалтын сан (JKATF) эсвэл JLRT сонсох/унших шалгалт (бичих шалгалт)-аас явуулсан Японы ханз бичгийн шалгалтын нийт оноо 400-аас доошгүй оноо авсан байх.

4) Өргөдөл гаргагч нь Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан технологийн сайдын санал дүгнэлтээр Хууль зүйн сайдын мэдэгдлээр хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын иргэнд япон хэл заах боловсролын байгууллагад зургаан сар ба түүнээс дээш хугацаагаар япон хэлний боловсрол эзэмшсэн байх (дээр дурдсан байгууллагад ирцийн хувь 90% ба түүнээс дээш байх).

5) Өргөдөл гаргагч нь Японы Сургуулийн боловсролын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу боловсролын байгууллагад 1 ба түүнээс дээш жил боловсрол эзэмшсэн байх (бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль, техникийн коллеж, ахлах коллеж, их сургууль, ахисан түвшний сургууль).

* Олон улсын бакалаврын зэрэг багтсан (дэлгэрэнгүй мэдээллийг лавлана уу).

(2) Өргөдөл гаргагч нь КСГ-д элссэн цагаасаа эхлэн төгсөх хүртэл Японд ямар ч саадгүй оршин суух шаардлагатай оршин суух зөвшөөрөлтэй (визийн зөвшөөрөлтэй).

* Гадаад оюутан, байнгын оршин суугч, Япон улсын иргэний хань, гэр бүлийн гишүүн гэх мэт.

(3) Өргөдөл гаргагчийн сурсан сургуулийн захирал эсвэл багшийн санал болгосон.

(4) Өргөдөл гаргагчийн Японд байх бүх зардлыг баталгаажуулна.

Элсэлтийн сонгон шалгаруулалт (гадаад оюутнуудын элсэлтийн шалгалт)

Баримт бичгээр сонгох Өргөдөл гаргагчийг ирүүлсэн баримт бичиг зэрэг дээр үндэслэн шалгана.

Ярилцлагын аргаар сонгон шалгаруулах Өргөдөл гаргагч нь ирүүлсэн бичиг баримтын үндсэн дээр ярилцлага, аман шалгалт өгдөг.

* Ярилцлага, аман шалгалтыг заасан газар болон онлайн видео чатаар (Zoom гэх мэт) авах боломжтой. Шалгалтыг онлайнаар өгөх өргөдөл гаргагч нь шалгалт өгөх үед гэртээ компьютер, микрофон, чанга яригч, камер, болон интернет холболт зэрэг онлайн харилцаа холбооны орчинг бүрдүүлсэн байх шаардлагатай (өргөдөл гаргагч нь шууд видео дамжуулах чадвартай байх ёстой).

* Өргөдөл гаргагчдад ярилцлага, аман шалгалт өгөх цаг, огноо, байршил (хэлбэр)-ийг шалгалтын элсэлтийн тасалбарыг илгээх үед мэдэгдэнэ. (Эдгээр нь ирүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш хоёр долоо хоногийн дотор илгээгддэг.)

Уян хатан онлайн анги

Flexible Online Course

Илүү их
судла



Олон улсын хэрэглээний мэдээлэл зүйн хөтөлбөр

Япон одоогоор IT-ийн боловсон хүчний хомсдолтой нүүр тулж байна. 2030 он гэхэд энэ хомсдол 450,000 орчимд хүрэх төлөвтэй байна. (Мэдээллийн технологийн боловсон хүчний эрэлтийн судалгаа (Тойм), METI, 2019 оны 4-р сар) Энэхүү хүндрэлтэй тулгарсан КСГ нь чадварлаг хүмүүсийг IT-ийн чиглэлээр суралцаж, дэлхийн IT-ийн салбарыг удирдуулахыг хүсдэг. Энэ зорилгын үүднээс КСГ нь уян хатан онлайн курсуудыг байгуулжээ.

Уян хатан онлайн курсуудын давуу тал

Хаана ч хамаагүй өөрийн хурдаар суралцаарай!

КСГ-ийн хамгийн сүүлийн үеийн сургалтын удирдлагын систем болох KING-LMS нь сургалтын нөөцөд 24 цагийн турш нэвтрэх боломжийг олгодог. KING-LMS-ийн тусламжтайгаар та урьдчилан бэлтгэсэн лекцийн видео бичлэг, хичээлийн материалыг ашиглан өөрийн хуваарийн дагуу хичээлд хамрагдах боломжтой. Та хүссэнээрээ лекц үзэж, сонсож, хичээлээ өөрийн хурдаар ахиулах боломжтой.

Ямар ч хичээлийг бүтэн цагийн курс болгон хувирга!

Уян хатан
онлайн
анги

- Арт, дизайн
- Бизнес ба менежмент
- Компьютерийн шинжлэх ухаан
- Дижитал тоглоом, зугаа цэнгэл
- Суулгагдсан системийн инженерчлэл

Сургуулиа төгсөөд Нарийн мэргэжилтний диплом аваарай!

Нарийн мэргэжилтний диплом нь тодорхой нөхцөлийг хангаж, ахисан түвшний мэргэжлийн сургуульд дөрвөн жилийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрагдсанаар авах боломжтой мэргэшил юм. MEXT нь Нарийн мэргэжилтний дипломыг их сургуулиас олгодог бакалаврын зэрэгтэй дүйцэхүйц гэж хүлээн зөвшөөрдөг. Нарийн мэргэжилтний дипломыг зөвхөн мэдлэг төдийгүй мэргэшсэн чиглэлээр ур чадвар эзэмшсэн хүмүүст олгодог. Иймд Нарийн мэргэжилтний дипломыг бакалаврын зэрэгтэй дүйцэхүйц эсвэл бүр илүү гэж үзэх нь улам бүр нэмэгдсээр байна. IT-ийн чиглэлээр суралцсан нарийн мэргэжилтний диплом эзэмшигчид ирэх эринд урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр хэрэгцээтэй байх төлөвтэй байна.

Сургалтаар дамжуулж эрчимтэй суралцах: Үр нөлөөгөө нэмэгдүүлээрэй!

Олон улсын хэрэглээний мэдээлэл зүйн чиглэлээр бид "Сургалт" хэмээх эрчимжүүлсэн хөтөлбөрийг санал болгож байна. Сургалтын хувьд оюутнууд багшийн шууд удирдлаган дор танхимаар эрчимжүүлсэн сургалтад хамрагддаг. Сургалт нь хоёр долоо хоногийн хугацаатай, жилд хоёр удаа: Зуны улиралд 8-р сараас 9-р сар хүртэл, хавар 2-р сараас 3-р сар хүртэл. Сургалтын ангиуд нь Киото вокзалаас долоон минутын зайд орших КСГ-ийн Киото Экимаэ кампусд байдаг. Тээврийн холболт нь маш сайн, ажилдаа явахад хялбар болгодог.

Хичээлийн хөтөлбөр

Танхимын хичээл

Анхны бүтээл туурвих, сорилтот төслүүдийг хэрэгжүүлэх

Үндсэн ангиуд

Төрөл бүрийн салбарт өргөн хүрээний мэдлэг олж авах

Хэрэглээний ангиуд

Төрөл бүрийн салбарт өргөн хүрээний мэдлэг олж авах

Ажил мэргэжлийн хариу арга хэмжээний ангиуд

Таны ажил хайхад дэмжлэг үзүүлнэ

Халуун дулаан тусламж дэмжлэг, олон улсын оюутнуудад зориулсан сайн чанарын ерөнхий боловсрол.

Нгуен Сы Нам

Ярилцлагын видео ▶

Мэдээлэл боловсруулах хөтөлбөр
Мэдээлэл боловсруулах анги

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс

Би үргэлж япон тоглоом, манга, анимэ үзэх дуртай байсан. Хэн нэгэн намайг гадаадад сурахыг санал болгосноор би цоо шинэ орчинд ирээдүйдээ бэлдмээр байна гэж шийдсэн. Япон хэлний сургуульд орснохоо дараа IT-ийн чиглэлээр суралцахыг хүссэн учир энэ нь ирээдүйн нийгмийг бүтээх хүч гэдгийг ойлгосон. Тиймээс би КСГ-д элссэн. КСГ нь олон улсын оюутнуудад зориулсан олон төрлийн дэмжлэгт хөтөлбөрүүдийг санал болгодог бөгөөд IT-ийн салбараас гадуурх ерөнхий боловсрол эзэмших олон боломжийг олгодог. Би хичээнгүйлэн суралцаж, Японы IT-ийн компанид элсэх боломжтой болсон. Орсоныхоо дараахан би IT-ийн инженерийн үндсэн шалгалтанд тэнцсэн.

Би хэзээ нэг өдөр олон улсын маркетингийн чиглэлээр ажилламаар байна.

Сукандар Ипунг Исмая

Бизнесийн IT хөтөлбөр

Бүгд Найрамдах Индонез Улс

Би үргэлж сонирхдог байсан Япон улсдаа суралцахыг хүссэн. Японд би IT-ийн чиглэлээр суралцахыг хүссэн, яагаад гэвэл энэ нь ирээдүйд зайлшгүй хэрэгтэй зүйл болох учраас бизнесийн чиглэлээр суралцахыг хүссэн. Тиймээс би КСГ-д бүртгүүлсэн. Би компьютерийн боловсролгүй байсан тул профессорууд маань тэвчээртэй бүх зүйлийг зааж өгсөн. Аажмаар мэдлэг, ур чадвар эзэмшиж, ахиц дэвшил гарч байгааг мэдэрч байлаа. Би гадаад маркетингийн чиглэлээр мэргэшсэн ажилд орохыг хүсч байна. Би Японы бүтээгдэхүүн, технологийг эх орон Индонези болон дэлхийд түгээхийг хүсч байна.

Би дэлхийн хамгийн агуу технологийг судлахыг хүсч байна.

Наташа Мария Девина

Бизнесийн IT хөтөлбөр

Бүгд Найрамдах Индонез Улс

Би технологийн салбарт тэргүүлэгч улс болох Японд суралцахыг хүссэн. Болдогсон бол нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр ажилладаг ээж шигээ болчих юмсан. Тиймээс би IT болон бизнесийн чиглэлээр мэдлэг, ур чадвар эзэмшихийн тулд КСГ-д элсэн орсон. Би компьютерийн талаар өөрөө өөртөө зааж ирсэн. Одоо би КСГ-ийн багш нараасаа суралцаж байгаа бөгөөд тэд надад эелдэг, тэвчээртэй ханддаг тул бизнестэй холбоотой хичээлүүд гэх мэт хичээлд сууж хөгжилдөж байна. Ирээдүйд би онлайн бизнес програмчлалын чиглэлээр ажиллах хүсэлтэй байна.

КСГ шилдэг шагнал надад итгэл өгсөн.

Лю Лангбяо

Ярилцлагын видео ▶

Дижитал тоглоом хөгжүүлэх үндсэн хөтөлбөр

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятадад их сургуулиа төгсөөд сүлжээний инженерээр ажиллаж байсан ч, улам бүр бүтээлч ажил хийх хүсэл эрмэлзэлтэй болсон. Би Киотогийн Япон хэлний сургалтын төвд суралцсанахаа дараа КСГ-д тоглоомын талаар суралцаж эхэлсэн. Намайг КСГ-д элссэний дараа профессорууд маань инженерийн мэдлэгийг үнэхээр сайн ойлгуулж өгсөн. Тэдний ачаар Япон найз бид хоёр хамтдаа бүтээсэн тоглоомоороо КСГ шилдэг шагналыг хүртсэн. Би хамгийн их сонирхож байсан тоглоомын компанидаа ажилд орох боломжтой болсон. Би багийн ахлагч болохын тулд ур чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлж байна.

Эх орондоо тоглоомын компани байгуулах нь миний мөрөөдөл.

Гил Жирон Андрес Франциско

Дижитал тоглоом хөгжүүлэх үндсэн хөтөлбөр

Бүгд Найрамдах Гватемал Улс

Манай улсад IT-ийн чиглэлээр мэргэжлээрээ ажиллах боломж хязгаарлагдмал байсан. Мөн манайд олон их сургууль байдаггүй, иймд би Японд ирэхээр шийдсэн. КСГ-ийн бүх хүмүүс найрсаг байсан бөгөөд би энд тоглоомын талаар суралцахад үнэхээр анхаарлаа төвлөрүүлж чадаж байна. Би маш их дадлага хийдэг бөгөөд энэ нь хөгжилтэй байдаг. Япон аюулгүй, байгаль орчин нь гайхамшигтай. Энд, Киото хотод би Араши уулын намрын өнгөний үзэсгэлэнт байдал болон үүнтэй төстэй зүйлд сэтгэл татагддаг. Би сургуулиа төгсөөд Японы компанид ажиллаж, туршлага хуримтлуулж, дараа нь нэг өдөр Гватемал руу буцаж ирээд тоглоомын програм хангамж хөгжүүлэх компани байгуулахыг хүсч байна.

Би эх орныхоо IT-ийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг хүсч байна.

Шахзодшохи Шамсиддин

Мэдээлэл боловсруулах хөтөлбөр
Мэдээлэл боловсруулах анги

Бүгд Найрамдах Тажикстан Улс

Манай дээд ангийн нэг сурагч Японд сурахаар явсан болохоор "Би ч гэсэн болно шүү дээ" гэж бодсон. Тиймээс би КСГ-д бүртгүүлсэн. Миний хувьд анх удаа IT-ийн чиглэлээр чармайн суралцаж байсан бөгөөд үнэхээр хэцүү байсан. Гэхдээ багш нар маань намайг маш эелдэгээр удирдаж, компьютерийн тоног төхөөрөмж нь хамгийн сүүлийн үеийн зүйлс байсан. Энэ нь тун хөгжилтэй байсан бөгөөд би оюутан ахуй цагтаа дуртай. Би сургуулиа төгсөөд Японд IT-ийн компанид ажилд орж, тэндээ дагалдан суралцаж, мөнгөө хуримтлуулж байгаад Тажикистан руу буцаж ирээд, програм хангамж хөгжүүлэх компани байгуулахыг хүсч байна. Эх орныхоо IT-ийн хөгжилд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Японд сүүлийн үеийн тоног төхөөрөмж ашиглан манга судалж байна.

Норманс Сагастум Хавьер Александр

Арт, дизайны хөтөлбөр
Манга, анимэгийн анги

Бүгд Найрамдах Гватемал Улс

Би Японд очиж манга зураач болохыг үргэлж хүсдэг байсан, учир нь би Японы мангагийн гүн гүнзгий, нарийн мэдрэмжинд татагддаг байсан. Тэгээд Япон сургуульд орснохоо дараа би КСГ-д элсэн орсон. КСГ манга судлах хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжтэй. КСГ-ийн профессорууд бүх зүйлийг нухацтай тайлбарлаж, асуулт асуухад хялбар орчин нөхцөлийг бүрдүүлдэг. Оюутны амьдрал маань маш сайхан өнгөрч, би түүнээсээ бүрэн дүүрэн таашаал авч байна. Сургуулиа төгсөөд Японы хэвлэлийн газар ажилд орно гэж бодож байна. Өөрийн гэсэн манга цувралтай болвол үнэхээр сайхан байх болно.

Нэгж систем нь надад өөрийн карьераа цуглуулах боломжийг олгодог.

Фрэнсис Даниел Кадер Оливарес

Мэдээлэл боловсруулах хөтөлбөр
Мэдээлэл боловсруулах анги

Бүгд Найрамдах Эль Сальвадор Улс

Японд Nintendo, Sega, Capcom зэрэг тоглоомын шилдэг технологиор сайрхдаг олон компаниуд байдаг бөгөөд тэд Латин Америкт өөрийн байр суурийг бий болгож байна. Би тэдгээр компаниудад зочилж очиж судалмаар санагдаад КСГ-д элсэн орсон. КСГ-ийн талаар миний хувьд үнэхээр гайхалтай зүйл бол нэгжийн систем юм. Би CPU, вэб програмчлал гэх мэт сонирхож буй зүйлийнхээ хичээлд сууж, өөрийн ирээдүйн мэдлэг боловсролоо авч чадна. Хэлний мэдлэгтэй болмогц би аялал жуулчлалтай холбоотой олон хэлээр ярьдаг вэб сайт хийх ажилд ормоор байна.

Би дэлхийн контентын бизнест оролцохыг хүсч байна.

Наранжо Бежарано Карлос

Дижитал тоглоом хөгжүүлэх үндсэн хөтөлбөр

Испанийн вант улс

Би Японы тэргүүний технологийг үргэлж биширдэг байсан. Покемон гэх мэт тоглоомууд хөгжилтэй бөгөөд технологи нь дэлхийн хаана ч байхгүй. Японд тоглоом сурахаас өөр юу ч намайг аз жаргалтай болгож чадахгүй. КСГ нь хамгийн сүүлийн үеийн компьютерийн техник болон программ хангамж бүхий гайхалтай сургалтын орчинг санал болгож байна. Миний зорилго бол Японы томоохон контент компанид орох явдал юм. Би япон, испани хэлээр ярьдаг тул IT-ийн мэдлэг эзэмшсэнээр дэлхийн бизнест оролцох боломжтой болно.

КСГ боловсролын үр дүнг мэдэрч байна.

Чанвонгнараз Кампасит

Мэдээлэл боловсруулах хөтөлбөр
Мэдээлэл боловсруулах анги

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс

Технологи нь хүмүүсийн амьдралыг илүү сэтгэл хангалуун болгодог. Би IT-ийн чиглэлээр суралцаж, нийгэмд үнэ цэнэтэй үүрэг гүйцэтгэхээр шийдсэн учраас КСГ-д элссэн. Японы анхны боловсролын байгууллага нь компьютер дээр төвлөрсөн тул IT-ийн боловсрол эзэмшсэн түүхтэй. Би үнэхээр сайн сургуульд элсэн орсон юм шиг санагдаж байна. Би өмнө нь хэзээ ч компьютер сурч байгаагүй болохоор эргэлзээтэй санагдсан. Аз болоход КСГ-ийн профессорууд маань надад бүх зүйлийг ойлгоход хялбар үгээр тэвчээртэйгээр тайлбарладаг. Үүнийг мэдэхээсээ өмнө би програмчлалд дуртай гэдгээ ойлгосон. Ирээдүйд би Японд IT-тэй холбоотой компанид ажил олж, програмчлалын ажлаа үргэлжлүүлэн, дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүсийн амьдралыг илүү хялбар болгох ажлыг хийхийг хүсч байна.

Япон хэл, видео технологи сурмаар байна.

Раламбозатово Нарияня Вололоняина

Арт, дизайны хөтөлбөр
Арт, дизайны анги

Бүгд Найрамдах Мадагаскар Улс

Япон улс эх орноос маань тэс өөр соёлтой учраас би сонирхсон. Би Мадагаскарын их сургуульд үзсэн видео болон гэрэл зургуудынхаа талаар илүү гүнзгий судлахыг хүссэн тул МЕХТ-ийн зөвлөмжийн дагуу КСГ-д элсэн орсон. Би КСГ-д суралцахаар ирсэндээ үнэхээр баяртай байна. Манай хичээл дээр багш нар маань анхан шатны мэдлэгээс эхлээд нарийн боловсрол олгодог. Сургагч багш нар болон манай ангийнхан бүгд сайхан сэтгэлтэй. Бид чөлөөт цагаараа хамт байдаг. Миний мөрөөдөл бол Японы соёлыг Мадагаскар болон дэлхийн бусад оронд видео бичлэгээр дамжуулан хүргэх явдал юм.

Тоглоомын програмчлалыг гүнзгийрүүлэн судлах.

Ким Хэ Ранг

Мэдээлэл боловсруулах хөтөлбөр
Мэдээлэл боловсруулах анги

Бүгд Найрамдах Солонгос Улс

Миний сурч байсан охидын ахлах сургууль КСГ-тэй хамтран ажилладаг бөгөөд манай ахлах ангийн нэг сурагч тэнд сурахаар явсан тул КСГ надад танил санагдсан. Сургууль нь компьютер болон бусад тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бөгөөд тусгай боловсрол эзэмшиж чадна гэдгийг би мэдэж байсан. Би тоглоомын програмчлалд суралцахыг хүссэн, учир нь Японд хийдэг үлгэр-хэлбэрийн тоглоомуудад дуртай байсан тул КСГ-д элссэн. Миний мөрөөдөл бол хэзээ нэг өдөр Японы тоглоомын компанид программистаар ажиллах юм. Хэрвээ би өөрийнхөө төсөөллөөр тоглоом бүтээж, дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүст таалагдаж чадвал би үнэхээр баяртай байх болно.

FOUR SEASONS

Оюутны жилийн дөрвөн улирал

КСГ-д жилийн туршид олон төрлийн үйл ажил, арга хэмжээг зохион явуулдаг.

- Тайлбар танилцуулга
- Элсэлтийн баяр
- Эрүүл мэндийн үзлэг
- Хаврын улирлын сургалт эхлэнэ
- Нэгдүгээр курсын оюутнуудад зориулсан танилцах үдэшлэг
- Хаврын улирлын улсын шалгалт
- Нэгдүгээр курсын өдрийн камп
- Хаврын явган аялал
- Сургууль дээрх компаниудын танилцуулга

4 сар

Киотогийн жилийн туршид зохион байгуулагдах гол үйл ажиллагаанууд

Тоёотоми Хидэёши
Сакура цэцэг үзэх парад
(Даигожи хийд)

April



Элсэлтийн баяр

- Байгуулагдсаны ойн өдөр (5 сарын 1 өдөр)
- Спортын тэмцээн
- Сургууль дээрх компаниудын танилцуулга

5 сар

Киото Такиги Но
(Хэйан-жингү сүм)

May



Хаврын явган аялал



Хөгжмийн тоглолт

- Хөгжмийн тоглолт
- Сургууль дээрх компаниудын танилцуулга

6 сар

Киото Такиги Но
(Хэйан-жингү сүм)

June

- Соёлыг таниулах лекц
- CG тест
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх танилцуулга
- Сургууль дээрх компаниудын танилцуулга
- Зуны фестиваль

7 сар

Гионы наадам
(Ясака сүм,
Киотогийн бусад газар)

July



Зуны фестиваль



Япон өдөр өдөрлөг

- Хаврын улирлын сүүл үе
- Хаврын улирлын шалгалт
- RIT-ийн зуны семинар
- Зуны амралт
- Зуны улирлын шалгалтанд бэлтгэх семинар
- Зуны сургалт эхэлнэ
- Бизнесийн дадлага
- Ажлын байрны зөвлөгөө
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх танилцуулга

8 сар

Гозан ёслолын галын наадам
(Даймонжияма гэх мэт)

August



Киотогийн мэргэжлийн сургуулиудын спортын наадам



Ажлын байрны зөвлөгөө

- J тест, мэдээллийн системийн шалгалт
- Киотогийн мэргэжлийн сургуулиудын спортын наадам
- Сургууль дээрх компаниудын танилцуулга
- Намрын улирлын сургалтын удирдамж
- Хөгжмийн тоглолт
- Эрүүл мэндийн үзлэг

9 сар

Сар ажиглах орой
(Даикакүжи хийд)

September

- Намрын сургалт эхлэнэ
- Намрын улсын шалгалт
- Намрын явган аялал
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх танилцуулга

10 сар

Эрин үеийн наадам
(Хэйан-жингү сүм)

October



Намрын явган аялал

- 11 сарын баяр
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх танилцуулга
- Мэргэжлийн хичээлийн лекцүүд
- Урлагын тоглолт
- CG тест
- Эцэг эхчүүдийн зөвлөгөөн

11 сар

Арашияма Намрын Наадам
(Арашияма)

November



11 сарын баяр



Өвлийн сургалт

- Соёлыг таниулах лекц
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх танилцуулга
- Өвлийн амралт

Окера наадам
(Ясака сүм)

12 сар

December

- Бататгах хичээлүүд
- Хөгжмийн тоглолт
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх танилцуулга

1 сар

Алсын харваа
(Санжусангендо хийд)

January



КСГ AWARDS Оюутны уран бүтээлийн тайлан

- Намрын улирлын сүүл үе
- КСГ AWARDS
- Намрын улирлын шалгалт
- J тест, мэдээллийн системийн шалгалт
- Хаврын амралт
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх танилцуулга
- Сургууль дээрх компаниудын танилцуулга
- Өвлийн сургалт эхлэнэ

2 сар

Чавганы цэцгийн баяр
(Китано-тенмангү сүм)

February



Төгсөлтийн ёслол



Төгсөлтийн баяр

- Хаврын сургалт
- Төгсөлтийн ёслол
- Төгсөлтийн баяр
- Сургууль дээрх компаниудын танилцуулга
- Хаврын улсын шалгалтанд бэлтгэх семинар

3 сар

Бамбарын наадам
(Сейрожи хийд)

March

Киото япон хэл сургалтын төв (KJLTC)



Бүтэн цагийн хичээл 1 жил

4 сард элсэн орно

Бүтэн цагийн хичээл 1 жил хагас

10 сард элсэн орно

※ Хамрагдах хүн: Япон хэлний түвшин тогтоох шалгалт N3-N5-р түвшний япон хэлний мэдлэгтэй хүн

- KCG-н гадаад оюутны тусгай анги болох Киото япон хэл сургалтын төв (KJLTC: Kyoto Japanese Language Training Center)-д японы дээд боловсролын байгууллагад элсэн ороход зориулсан япон хэлний сургалт явуулдаг. KJLTC нь хууль зүйн сайдын заасан япон хэлний боловсролын байгууллага сургууль юм.
- Тус курс нь боловсролын яамнаас тогтоосон “Бэлтгэл боловсролын” (Зөвхөн дотоодын 26 сургууль, гадаадын 2 сургууль) юм. Өөрийн орны боловсрол эзэмших жил нь 12-с доош жилийн хугацаатай байсан хүн байсан ч, тус курсыг дүүргэснээр, KCG-н үндсэн ангиас эхлээд, японы дээд боловсролын багууллагад элсэн суралцах эрхтэй болно.
- KCG-н үндсэн ангид элсэн орох бэлтгэл сургалт болох процессор, хүснэгт тооцоо зэрэг хэрэглээний программ хангамжийн үйлдлийн дадлага (Мэдээллийн технологийн суурь мэдлэг)-г зайлшгүй үзэх хичээл гэж үзнэ. Авсан кредитийг элсэн орсны дараа үндсэн ангийн кредит дээр нэмж тооцно.
- Зохих түвшний япон хэлний чадвартай оюутан тус курст сурангаа, KCG-н үндсэн ангийн компьютерын мэргэжлийн хичээлд суух боломжтой.
- Тус курсыг төгссөний дараа, KCG-н үндсэн ангид элсэн суралцах оюутанд элсэлтийн хураамж, сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ. Мөн, KCG-н үндсэн оюутнаар элсэн орох оюутан сургалтын төлбөрт үзүүлэх систем (тэтгэлэг)-д хамрагдах болно.

Япон хэлтэй холбоотой хичээлийн тухайд, элсэлтийн шалгалт болон улирлын эцсийн шалгалтын дүнгээс хамааран хэлний түвшинд нийцэх ангид хуваагдан хичээллэх болно. 7 сар болон 12 сард япон хэлний түвшин тогтоох шалгалтын N2 эсвэл N1-р түвшний шалгалт өгөхөд тусална. Мөн, “Японд сурах шалгалт”-нд бэлтгэнэ.

◆ Курсын танилцуулга

Бэлтгэл ангийн сургалт

Японы дээд боловсролын байгууллага (Их дээд сургууль, тусгай мэргэжлийн сургууль гэх мэт)-д элсэн орохын тулд японд болон өөрийн орондоо 12 жилийн анхан болон бүрэн дунд шатны боловсрол эзэмшсэн байх ёстой. Гэвч, тус тусын орны боловсролын системд тулгуурласан боловсрол эзэмших жил 12-с доош байх тохиолдолд, тус сургуулийн курсыг дүүргэснээр, японы дээд боловсролын байгууллага (Их дээд сургууль, тусгай мэргэжлийн сургууль гэх мэт)-д элсэн суралцах эрхтэй болно. (Боловсролын яамнаас тогтоосон Бэлтгэл ангийн сургалт)

Хичээлийн хөтөлбөр

Япон хэлний хичээл

- Японы дээд боловсролын байгууллага (Их дээд сургууль, тусгай мэргэжлийн сургууль гэх мэт)-д элсэн ороход шаардлагатай япон хэлний чадвартай болгох, япон хэлний N1, N2-р түвшин тогтоох шалгалтанд бэлтгэнэ.
- Оюутны япон хэлний түвшинд тохируулан, зохих түвшний ангид хуваарилж хичээл заана.
- 1 долоо хоногт 20-с дээш цагийн япон хэлтэй холбоотой хичээлд хамрагдана. (1 улиралд 20 долоо хоног, 1 жилд 40 долоо хоног)

Хичээлийн нэр	Агуулга
Япон хэл 1 (Өгүүлбэр зүйн дүрэм, үсэг, үгсийн сан)	Өгүүлбэр зүйн дүрэм, ханз, үгсийн сангаа арвижуулж, нийгмийн амьдрал, мэргэжлийн салбарт шаардлагатай ерөнхий япон хэлний чадвартай болно.
Япон хэл 2 (Сонсох, яриа)	Өдөр тутмын болон нийгмийн амьдрал, мэргэжлийн салбарт шаардлагатай аман ярианы хэллэгээс сурч, сонсож ойлгох дасгал хийнэ.
Япон хэл 3 (Унших)	Нийгмийн амьдрал, мэргэжлийн салбарт зайлшгүй хэрэгтэй болох уншиж ойлгох чадварыг хөгжүүлэх болон сонин, сэтгүүл, дипломын ажил, уран зохиолын бүтээл зэргийг уншиж ойлгох дасгал хийнэ.
Япон хэл 4 (Зохион бичлэг)	Эссе, реферат, И-мэйл, PowerPoint, бизнесийн баримт бичиг бичнэ.
Японы байдал	Японы соёл, нийгэм, мөн япон хүний үзэл бодол болон ёс зүйн талаар ойлголцоттой болно.

Япон хэлний түвшин тогтоох шалгалт болон японд суралцах шалгалтанд бэлтгэх анги

Зохих түвшний ангид хичээллэнэ.

Хичээлийн нэр	Агуулга
Ерөнхий япон хэл	Япон хэлний түвшин тогтоох шалгалт болон японд суралцах шалгалтын асуултанд бэлтгэх зэргээр түүний чиг хандлагын судалгаа, зохих арга хэмжээг авна.

Үндсэн хичээлүүд

Япон хэлээс бусад ур чадвараа дээшлүүлэн, дээд боловсрол эзэмшихэд шаардлагатай мэдлэгтэй болно.

Хичээлийн нэр	Агуулга
Үндсэн хичээлүүд	Англи хэл, математик, шинжлэх ухаан (физик, хими, биологи), иж бүрэн сургалт, мэдээллийн технологийн суурь мэдлэг (компьютер)

※ Долоо хоногт 6-8 цаг хичээллэнэ.



◆ Элсүүлэх курс (Сурах хугацаа) болон агуулга, элсүүлэх хүний тоо

Элсэлтийн хугацаа	Курсын нэр	Агуулга	Элсэх хүмүүсийн тоо
Дөрөвдүгээр сар	Их сургуулийн бэлтгэл 1 жилийн курс (1 жил)	Японы дээд боловсролын байгууллага (Их дээд сургууль, тусгай мэргэжлийн сургууль гэх мэт)-д элсэн орох хүсэлтэй хүнд зориулсан	60 хүн
Аравдугаар сар	Их сургуулийн бэлтгэл Жил хагасын курс (1.5 жил)		60 хүн

◆ Элсэлтийн нөхцөл

Дараах зүйлийг бүгдийг нь хангасан байх

- ① Гадаад улсад дээд боловсролын сургалтанд хамрагдсан байх. (12-с доошгүй жил болон 12-с дээш жил боловсрол эзэмшсэн хүн байх)
- ② Япон хэл сурах эрмэлзэлтэй, япон хэлний түвшин тогтоох шалгалт N5 (4-р түвшин)-с дээш мэдлэгтэй, япон хэлийг сурч эзэмших идэвхи зүтгэлтэй хүн байх.
- ③ Японы дээд боловсролын байгууллага (Их дээд сургууль болон мэргэжлийн сургууль гэх мэт)-д элсэн суралцахад шаардлагатай суурь мэдлэг боловсролтой хүн байх.
- ④ Ахлах сургууль төгссөн 23-с доош насны, коллеж төгссөн 25-с доош насны, их сургууль төгссөн 27-с доош насны хүн байх
- ⑤ Сургалтын төлбөр болон ахуй амьжиргааны зардал зэрэг японд байх хугацаанд шаардлагатай зардлыг гаргаж чаддаг байх
- ⑥ Бие сэтгэлийн хувьд эрүүл саруул, япон улсын хууль тогтоомж болон тус сургуулийн дүрэм журам, заалтыг чандлан дагаж мөрддөг байх.

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль (KCGI) IT-ийн чиглэлээр хамгийн сайн судалгаа хийхийг зорин ажиллаж байна.

KCGI: The Kyoto College of Graduate Studies for Informatics

KCGI-ийг төгссөний дараа манай Группын боловсролын байгууллага болох KCGI-д дэвших карьерийн нэг зам таньд нээлттэй байна. KCGI бол Японы IT-ийн чиглэлээр мэргэшсэн анхны төгсөлтийг бэлтгэсэн сургууль юм. KCGI-н хөтөлбөрийг төгссөн оюутнуудад IT-ийн шинжлэх ухааны магистр зэрэг (Мэргэжлийн зэрэг) олгодог. Энэ зэрэг нь Японд хэрэглээний IT-ийн салбарын оргил үе юм. Зарчмын хувьд KCGI-д элсэхийн тулд дөрвөн жилийн хугацаатай их дээд сургууль төгсөх эсвэл мэргэжлийн сургуулийн дөрвөн жилийн сургалтыг төгссөний дараах нарийн мэргэжлийн диплом шаарддаг. Гэсэн хэдий ч KCGI-ийг төгссөн оюутнууд дараахь тусгай нөхцлөөр элсэх боломжтой. (Удирдамжийг үзнэ үү).

◆ KCGI-ийн давуу талууд

Бүх хичээлүүд “Англи хэл” дээр орох тул оюутнууд зөвхөн Англи хэл дээр суралцах боломжтой	
KCGI нь зөвхөн англи хэл дээр олон тооны сургалт явуулдаг тул оюутнууд тухайн хөтөлбөрөө англи хэл дээр бүрэн дүүргэж магистрын зэрэг авах боломжтой. Эдгээр сургалтуудын ихэнхийг гадаадаас ирсэн дээд түвшний багш нар заадаг. Одоогийн байдлаар KCGI-ийн кампуст хилийн чанад дахь 17 улс, бүс нутгаас ирсэн гадаад оюутнууд байрлаж байна (2024 оны 3-р сарын төгсөгчдийг оролцуулаад). Эдгээр оюутнуудын ихэнх нь англи хэл дээр хичээлүүдээ сонгодог.	
Нийгэмд үр өгөөжөө өгөх практик ур чадварын үндэс суурь	IT-ийн салбарт ажиллаж хувийн карьераа эхлүүлэх боломжтой
- Салбарын хэрэгцээ, IT-ийн дэвшлийг харгалзан сургалтын төлөвлөгөө боловсруулдаг. - Сургалтын практик боломжийг газар дээр нь бүрэн агуулсан сургалтын хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг олгодог. - Цахим сургалтыг бие даасан хичээлтэй хослуулсан боловсролын үр дүнтэй аргаар хичээлүүдээ явуулдаг.	- Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гээд олон салбараас элсэгчид хүлээн авах боломжтой. - Оюутнууд элсэхдээ өөрсдийн мэдлэгийн түвшин дээрээ тулгуурлан хичээлээ сонгон эхлэх боломжтой.
IT (Мэдээллийн харилцаа холбооны технологи) ба Менежментийн тэнцвэртэй байдлыг судлах	Дэлхийн тавцанд гарахыг зорьж байна
- IT болон Менежмент гэх мэт олон мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг хөгжүүлэх. - Мэргэжлийн туршлагатай, хувийн хэвшилд IT-ийн стратегийг бий болгосон олон тооны багш нартай.	Дэлхийн улс орнуудын IT-ийн салбарын тэргүүлэгчид хичээлүүдийг удирдаж явуулна
Сурч мэдсэн зүйлээ ашиглан нийгэмд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой	
- Гайхалтай чиглүүлгийн ачаар өөрт хамгийн тохиромжтой ажил мэргэжлийн карьераа эхлүүлэх боломжтой. - Төгсөгчидтэйгөө холбоотой байх.	

“Өргөдөл гаргагч нь KCG-д гурван жилийн хугацаатай хөтөлбөр төгссөн байх, KCGI-д элссэн жилийнхээ 4-р сарын 1-ний байдлаар 22 болон түүнээс дээш настай байх ёстой бөгөөд академийн үр дүнгийн үнэлгээнд үндэслэн элсэлтийн болзол буюу элсэх эсэхийг шийдвэрлэнэ. Тиймээс их дээд сургуулийн төгсөгчтэй тэнцүү буюу түүнээс дээш академик чадвартай болохыг хүлээн зөвшөөрч буй юм”. KCG-ийг төгсөөд KCGI-д элсэх нь хэрэглээний IT-ийн оргилд хүрэх хамгийн хурдан зам юм. KCG-д Техникийн ахисан шатны диплом аваад, дараа нь KCGI-д магистрын зэрэг хамгаалахыг зөвлөж байна.

◆ Курсын бүрэлдэхүүн хэсэг



Оюутны хот Киото

Байгуулагдсанаас хойш 1200 гаруй жилийн түүхтэй Киото хот нь эртний үеэс эхлээд Японы соёлын төв газар, олон улсын хот байсан ба орчин үеийн олон залуучуудын амьдрах дуртай оюутнууд хот ч юм.

KCG-н оюутны кампус нь зам тээврийн сүлжээнд ойрхон, Киото хот дотроо түүнчлэн Осака, Нара болон Кобе Оцү (Шига муж) зэрэг Кансай бүс нутгуудад чөлөөтэй явж болох тээврийн сүлжээтэй юм.

KCG Киото Экимаэ Кампусын эргэн тойрон (KCGI Киото Экимаэ хиймэл дагуул)

JR, Кинтэцү, метроны шугмаар холбогддог Киотогийн буудал бол бүх улс орны өнцөг булан бүрээс олон хүн ирж очдог Киотогийн үүд хаалга юм. Буудлын ойролцоо орчин үеийн барилга байгууламжууд түүхэн барилгатай зэрэгцэн оршдог ба эрс ялгаатай уур амьсгалыг та мэдрэх болно.

Үзэх газар

- | | |
|------------------------------------|----------------------------|
| Тожи сүм | Санжюусангэндо хийд |
| Хигаши Хонган сүм, Ниши Хонган сүм | Улсын нэрэмжит Киото музей |
| Тофүкү сүм | Киото буудлын барилга |
| Киотогийн цамхаг | Киотогийн аквариум |



KCG Камогава Кампусын эргэн тойрон

Киотогийн гурван том наадмын нэг Aoi Yukari-н дор Шимогамо хийд болон Куотогоуен зэрэгт ойрхон байдаг байгалийн үзэсгэлэнт газраар баялаг хэсэг юм.

Үзэх газар

- | | |
|---------------|---------------------------|
| Шимокамо хийд | Киото хотын түүхийн музей |
| Киото гёэн | |
| Тадасүгийн ой | |



KCG Ракүхокү Кампусын эргэн тойрон

Китаожи метроны буудал, автобусны терминал, Ракүхокү бүсийн Киотогийн төвөөр нэвтрэн Киото буудал руу холбогдсон тээврийн сүлжээ сайтай. Орчин үеийн өндөр барилгуудтай Китаяма гудамжийн ойролцоо, Aoi Yukari-н, Камигамо хийд байдаг ба ургамлын хүрээлэн, Мидоро цөөрөм, Камо гол үзрэг байгальтай ойрхон газарт оршино.

Үзэх газар

- | | |
|--|----------------------------------|
| Камигамо хийд | Киото мужийн Ботаникийн цэцэрлэг |
| Мидоро цөөрөм (Мөн Мизорога-Икэ цөөрөм гэж нэрлэдэг) | Китаяма гудамж |

Киотогийн төв сургууль, KCGI Хиакуманбен Кампусын эргэн тойрон

Мүромачи соёлын бэлэг тэмдэг Гинкакү сүм, Киотогийн гурван том наадмын нэг Юкаригийн энх тайвны хийд, интоорын модоороо нэрд гарсан гүн ухааны зам, япондоо хамгийн хуучнаараа хоёрт ордог амьтны хүрээлэн, Киото хотын амьтны хүрээлэн, Киото хотын дүрслэх урлагын музей зэрэг олон үзвэрийн газруудтай, Киотогийн олон түүх, соёлын газруудыг үзэх боломжтой.


Үзэх газар

- | | |
|----------------------------------|--|
| Гинкакү мөнгөн сүм | Киото хотын амьтны хүрээлэн |
| Гүн ухааны зам | Хэйанжингү хийд |
| Нанзэн сүм | Эйкандо хийд |
| Киото хот KYOCERA урлагийн музей | Чион сүм |
| | Улсын нэрэмжит орчин үеийн урлагын музей |



kcg.edu боловсролын сүлжээ

Киото компьютерийн Гакүин (KCG) нь KCG группын боловсролын бусад байгууллагатай нягт холбоотой сүлжээгээр холбогдон, гадаад улсын засгийн газар, их дээд сургуультай хамтран ажиллаж, боловсролын байгууллагаар дамжуулан, мэдээллийн технологийг манлайлан, дэлхийн өндөр түвшний мэдээллийн технологийн боловсролыг түгээхийг зорьж байна.



Кампусууд

Киото Экимаэ Кампус

Киото Экимаэ кампус нь оюутны амьдралд хамгийн тохиромжтой газар байрладаг бөгөөд Киотогийн буудлаас баруун зүгт долоон минут алхаад хүрнэ. Мөн кампусын ойролцоо хоолны газрууд, томоохон худалдааны төвүүд, их дэлгүүрүүд зэрэг олон тооны жижиглэн худалдааны төвүүд болон дэлгүүрүүд байдаг.

Кампусын үндсэн барилга

Киото станцын баруун талд байрлах гайхамшигтай, цагаан ханатай барилга нь кампусын хамгийн сүрлэг барилга юм.



Залгаа барилга

Энэхүү гол барилгаас угсруулан барьсан задгай хэлбэрийн засалтай барилга нь цахим сургалтын студи болон Автомашины хяналтын курст ашигладаг автомашин, мотоциклийн удирдлагын дадлага хийхэд ашиглагддаг. Киото Экимаэ кампусын үндсэн барилга болон нэмэлтээр барьсан энэхүү барилгууд нь Киото хотын IT-ийн тэргүүлэх төв юм.



Ракухоку Кампус

KCGI -н хамгийн эртний уламжлалтай Ракухоку кампус нь маш олон төгсөгчдийг ажлын байртай болгосон. Ракухоку кампус нь Шимогамо дүүргийн нам гүм орчинд байрлалтай бөгөөд эрдэм шинжилгээний ажилд шамдаж буй хүмүүст хамгийн тохиромжтой орчинтой.



Техникийн коллеж

Камогава Кампус


Дизайны коллеж

Камогава кампус нь Камогава голын эрэг дээр нарны гэрэл, зөөлөн салхиар бүрхэгдсэн орчинтой. Камогава кампус бол хүсэл эрмэлзэлтэй залуу дизайнерууд болон бүтээлч хүмүүсийг татдаг чөлөөт сэтгэлгээтэй дижитал урлагийн сургууль юм. Кампусын ойролцоо урсдаг Камогава гол ба голын дагуух эрэг нь оюутнуудад уран сэтгэмжийг төрүүлж, тайвшрах орчныг нь бүрдүүлж өгдөг.



Кампусын бүх хичээлийн байрнуудыг явуулын автобусаар холбосон.

Кампусын бүх байрнуудын хооронд үнэгүй, зориулалтын автобусны үйлчилгээг холбосон учир оюутнууд автобусаар бусад байранд хичээллэх ангиудад хамрагдах боломжтой.



Киото мужийн гэрчилгээжүүлсэн мэргэжлийн сургууль (Техникийн хөтөлбөр)

Киото компьютерийн Гакүин (KCG)

<https://www.kcg.ac.jp/>

Техникийн коллеж Ракухоку Кампус

17 Shimogamo-honmachi, Sakyo-ku, Kyoto-shi, Kyoto 606-0862

Дизайны коллеж Камогава Кампус

11 Tanakashimoyanagi-cho, Sakyo-ku, Kyoto-shi, Kyoto 606-8204

Киото Экимаэ Кампус

10-5 Nishikujo, Teranomae-cho, Minami-ku, Kyoto-shi, Kyoto 601-8407

- Бизнес ба менежмент мэдээлэл зүйн хөтөлбөр (4 жил)
- Компьютерийн шинжлэх ухааны хөтөлбөр (4 жил)
- Дэвшилтэт дижитал тоглоом, зугаа цэнгэлийн хөтөлбөр (4 жил)
- Манга, анимэгийн хөтөлбөр (3 жил)
- Хэрэглээний мэдээлэл зүйн хөтөлбөр (3 жил)

- Суулгадсан системийн хөтөлбөр (4 жил)
- Компьютерийн инженерийн хөтөлбөр (3 жил)
- Компьютерийн инженерийн үндсэн хөтөлбөр (2 жил)

- Арт, дизайны мэдээлэл зүйн хөтөлбөр (4 жил)
- Арт, дизайны ахисан түвшний хөтөлбөр (3 жил)
- Арт, дизайны хөтөлбөр (2 жил)

- Мультимедиа тооцоолох хөтөлбөр (3 жил)
- Компьютерийн сүлжээний хөтөлбөр (3 жил)
- Дижитал тоглоом хөгжүүлэх хөтөлбөр (3 жил)
- Бизнесийн IT хөтөлбөр (2 жил)
- Эмнэлгийн оффисийн удирдлагын хөтөлбөр (2 жил)
- Мэдээлэл боловсруулах хөтөлбөр (2 жил)
- Дижитал тоглоом хөгжүүлэх үндсэн хөтөлбөр (2 жил)
- Мэдээлэл, харилцаа холбооны анги (1 жил/2 жилийн оройн анги)
- Олон улсын хэрэглээний мэдээлэл зүйн хөтөлбөр (4 жилийн онлайн анги)

Киото автомашинны мэргэжлийн сургууль (KCGM)

73 Tojihigashi-monzencho, Minami-ku, Kyoto-shi, Kyoto 601-8428

<https://kyoto-jidousha.ac.jp/>

■ Автомашинны засвар үйлчилгээний инженерийн хөтөлбөр

Киото япон хэл сургалтын төв (KJLTC)

11 Tanakashimoyanagi-cho, Sakyo-ku, Kyoto-shi, Kyoto 606-8204

<https://www.kjltc.jp/>

Киотогийн мэдээлэл технологийн эрдмийн зэрэг олгох их сургууль (KCGI)

Вэб бизнесийн технологийн чиглэлээр мэргэшсэн Хэрэглээний мэдээллийн технологийн дээд сургууль 7 Tanakamonzen-cho, Sakyo-ku, Kyoto-shi, Kyoto 606-8225

<https://www.kcg.edu/>